

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-28
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	29-70

<i>1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	29-39
<i>2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	39-70
<i>3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	70

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
10 дугаар сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Заяабал;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Р.Батболд, Г.Ганбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ж.Ганбаатар.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, мөн ажлын албаны шинжээч Б.Пунцаг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Шинэхүү, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Саранцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Ажлын хэсгийн тусгайлсан саналыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг зүйл, заалт бүрээр хэлэлцэв.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Жаргалан, Б.Заяабал, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 22.5.22 дахь заалтын үзэл баримтлалд нийцсэн гэснийг үзэл баримтлалд туссан гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг 22.5.11, 22.5.20, 22.5.21-д заасан хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 3

Бүгд: 14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “2 дугаар зүйл” нэмэх:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөлөх” гэсний дараа “, хөнгөлөх” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 11 дэх хэсгийн “, сонгон шалгаруулах этгээдийг” гэснийг “болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 9 дэх заалтын “болон бусад үйл ажиллагааны” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн “10”, “12” дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Төслийн заалттай холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд, Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх” заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх” заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь” дэд заалт нэмэх:

“3/хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	10
Бүгд:	14

28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “4 дэх” дэд заалт нэмэх:

“4/инновац шингэж шинээр бүтээгдсэн, олон улсад туршигдсан бараа, материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршлагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
-------------	---

Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “3 дахь” заалт нэмэх:

3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөлт эдлүүлэх төслийн жагсаалттай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “олон нийтэд” гэсний дараа “нээлттэй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “төрийн болон орон нутгийн өмчит” гэсний дараа “, төрийн өмчийн оролцоотой” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 6 дахь дэд заалтын “төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын” гэснийг “санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо,

Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Ажлын хэсгийн тусгайлсан саналыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нар тус тус танилцуулав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Мал, аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16,492.5 сая төгрөгийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	5
Бүгд:	14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮІ.1.1.29.Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 70,105.1 сая төгрөг, санхүүжих дүн 20,802.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХХІ.1.6.Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга, 80 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 14,587.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,118.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮІ.1.1.42.Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 22,607.2 сая төгрөг, санхүүжих дүн 13,030.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах, ХҮШ.1.18.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 600.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон ХІҮ.1.1.77.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 1,560.0 сая төгрөг, санхүүжих дүн 780.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, нийт 12,880.0 сая төгрөгийн эх үүсвэрээр ХҮШ.1.12.Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, бохир усны гол магистрал шугам 2 дугаар ээлж /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Тахилт, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,293.2 сая төгрөг, санхүүжих дүн 4,090.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,417.0 сая төгрөгөөр, Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, залууст чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Ховд аймагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зориулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцыг 2,000.0 сая төгрөгөөр, ХІХ.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,463.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХІҮ.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, ХІХ.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд тусгагдсан 49.8 тэрбум төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгон зориулалтыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 17.3.5.1.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох гэсэн төсөл, хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХХ1.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/ гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацаа, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь” гэж, 8.1.3 дахь заалтын “хэрэгжилтэд” гэсний дараа “хяналт” гэж, 9.1.1.3 дахь дэд заалтын “дүгнэлт” гэсний дараа “өгөх” гэж, 10.1.2.1 дэх дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Улсын Их Хурлын” гэж, 13.1.10 дахь заалтын “гомдол” гэсний өмнө “зөрчлийн талаарх” гэж тус тус нэмэх.

2.Төсвийн 1 дүгээр хавсралтын 1.1.2 дахь заалтын “бэхжүүлж” гэснийг “хангаж” гэж, 1.2.1 дэх заалтын “Монгол Улсын төр засгийн удирдлага ба төв байгууллагууд” гэснийг “Төрийн байгууллага” гэж, 4.1.1 дэх заалтын “шударга, шуурхай шүүхээр” гэснийг “шударга шүүхээр шуурхай” гэж, 17.1.1 дэх заалтын “аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 25.1.1 дэх заалтын “эд зүйлийн илрүүлэлтийг 50” гэснийг “эд зүйлийн илрүүлэлтийг 85.5” гэж, “хэргийн илрүүлэлтийг 50” гэснийг “хэргийн илрүүлэлтийг 58” гэж, “арга хэмжээг 90” гэснийг “арга хэмжээг 92” гэж, 25.2.1 дэх заалтын “70” гэснийг “72” гэж, “85” гэснийг “86.1” гэж, 25.4.1.4 дэх дэд заалтын “чиглэлээр” гэснийг “ажиллагааны бодит биелэлт” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтын “өргөн”, “гадаад ертөнц”, “дотоодын” гэснийг, 1.2.1.1 дэх дэд заалтын “Дотоодын” гэснийг, 2.1.1.1 дэх дэд заалтын “Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж,” гэснийг, 13.1.1.6 дахь дэд заалтыг, 13.1.6 дахь заалтын “өөрт нь” гэснийг, 17.2.3.2 дахь дэд заалтыг бүхэлд нь, 21.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт буюу Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого “279,336.5 сая төгрөг” гэснийг “295,822.0 сая төгрөг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүхийн байрууд /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 61,600.0 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 10,383.7 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71,983.7 сая төгрөгийн эх үүсвэрийг доор дурдсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулах замаар гаргах: Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын IY.1.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/” төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.2.1.2.Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах /Бүсүүдэд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 11,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.1.3.2.Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 12,983.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.3.3.1.Татварын байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 8,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХХIY.1.1.Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,493.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,917.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр ХХIY.3.1.Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,942.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд тусгагдсан Нийгмийн халамжийн сангийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилт болох 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс зориулалтаар нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 13
Бүгд: 14
7.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын бүх төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2 “Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах”

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.2.2.1

Шалгуур үзүүлэлт: Гадаад улстай хийх хэлэлцээр

Хэмжих нэгж: Тоо

Суурь он: 2023

Суурь түвшин: 64

2025 оны зорилтот түвшин: 75” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн хөтөлбөр нэмэх:

“23.5 Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөр 23.5.1

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн

“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.5.1.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт
Хэмжих нэгж: Хувь
Суурь он: 2023
Суурь түвшин: 95
2025 оны зорилтот түвшин: 100” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрийн 27.1.1 дэх арга хэмжээг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.1.Зэвсэгт хүчнийг “Нисгэгчгүй нисэх хэрэгсэл”, “Дрон”, “Хиймэл оюун ухаан”-д суурилсан дэвшилтэт техник, хэрэгслээр хангах

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.1.1
Шалгуур үзүүлэлт: Техник хэрэгслийн хангалт
Хэмжих нэгж: Хувь
Суурь он: 2023
Суурь түвшин: 8.5
Зорилтот түвшин: 20” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.1.Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.2.1
Шалгуур үзүүлэлт: Бэлэн байдлын түвшин
Хэмжих нэгж: Хувь
Суурь он: 2023
Суурь түвшин: 18
Зорилтот түвшин: 28” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.3 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.3.Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.3.1

Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 25

Зорилтот түвшин: 30” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 9

Бүгд: 14

35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.4 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.4.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 10

Зорилтот түвшин: 15” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.2

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн

“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.5.2.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 95

2025 оны зорилтот түвшин: 100” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын IX.1.2.“Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮШ.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮШ.1.2.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Орон нутгийн төсвийн хэсэгт 1,100.0 сая төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсанаас Аудитын дүгнэлтэд үндэслэн Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9

Бүгд: 14
35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХХI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 18,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх Үүнд:

-ХҮ.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-ХҮI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

-ХҮI.1.1.15.Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 км /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-ХҮI.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-ХҮI.1.2.2.Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

-ХҮI.3.1.1.Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын YII.4.1.Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 15,645.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BFP-24mm” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг болон санхүүжих дүнтэй гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮШ.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.3.1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.3.1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,590.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,590.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ГҮ.2.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 154,491.7 сая төгрөг, санхүүжих дүн 30,444.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 28.5.Боловсролын сайд, хөтөлбөр 28.5.1, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ” гэснийг “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

25.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.5 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 200 ор /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,000.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

26.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.137.Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 6,710.4 сая төгрөг, санхүүжих дүн 5,910.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,100.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,810.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14

Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа үг хэлж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 12
Бүгд: 14
14.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

28.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.1.36.Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 9,618.3 сая төгрөг, санхүүжих дүн 4,555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, төсөвт өртөг 14,926.4 сая сая төгрөг, санхүүжих дүн 2,219.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.1.178.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2,100.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, ХҮҮ.1.1.31.Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 11,121.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,548.3 сая төгрөг гэсэн төсөл хэмжээний нэрийн “24 у/м” гэсний дараа “гэрэлтүүлэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
35.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

30.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.1.185.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг 2,160.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,300.0 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах /Сүхбаатар/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

31.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.1.24.Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 15,758.5 сая төгрөг, санхүүжих дүн 6,488.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХҮП.1.1.41.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний “Өгийнуур” гэсний дараа “Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдааны зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах дэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа тайлбар хийв.

32.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Урсгал зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд тусгагдсан 1,857,913.3 сая төгрөгийг Эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт 30 хувиар бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14

21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

33.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйл буюу Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 25 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг гэснийг 2,500,000.0 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14

21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

34.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн урсгал зардалд туссан Зээлийн үйлчилгээний төлбөр 1,303,370.7 сая төгрөг гэснийг 1,263,370.7 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14

21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

35.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дэх Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын 5.1.5 Эрсдэлийн санд тусгагдсан 53,562.6 сая төгрөгөөр бууруулж, 5 дугаар зүйлийн 5.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14

35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

36.Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.33.“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/, хэрэгжих хугацаа 2023-2026 он, төсөвт өртөг 135,583.3 сая төгрөг, санхүүжих дүн 34,278.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,900.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Улаан-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам 2.1 км /Увс, Улаангом сум, 5-р баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,400.0 сая төгрөг,

санхүүжих дүн 2,400.0 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн автомашины зогсоол /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

37.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал”-ыг 9,278.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр XIX.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 9,278.5 сая төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

38.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 200 ор, /Завхан, Улиастай сум 3 дугаар цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 4,510.1 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

39.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХY.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 20,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,850.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн үйлдвэрийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,350.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, санхүүжих дүн 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,200.0 сая төгрөгөөр бууруулж, ХСҮТ-д Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар/, төсөвт өртөг 13,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл /Улаанбаатар/, төсөвт өртөг 5,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,700.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

41.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 14,700.0 сая төгрөгөөр бууруулж, Үерийн хамгаалалтын далангийн засвар шинэчлэлт /Дархан-Уул, Дархан сум 1, 2, 3 дугаар баг/, төсөвт өртөг 7,321.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг, Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам II үе шатны ажил /Дархан-Уул/, төсөвт өртөг 9,723.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/, төсөвт өртөг 17,147.9 сая төгрөг, санхүүжих дүн 5,700.0 сая төгрөг, Өргөх насос станцын тоноглол /Дархан-Уул, Дархан сум/, төсөвт өртөг 8,535.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

42.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66км /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр бууруулж, ХҮИ.1.1.70.Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр 217 у/м, хатуу хучилттай авто зам, 0,4 км /Баян-Өлгий, Алтанцөгц сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь зарчмын зөрүүтэй санал гаргах талаар үг хэлж, хуралдааны дэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 05 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 21 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
18 цаг 20 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хороодоос ирсэн материалууд, бас Зарлагын хяналтын хороон дээр гарсан саналууд энэ бүгдийг тараая. Байнгын хорооны гишүүдийн ирцийг эхлээд би танилцуулаадахъя. Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулаадахъя. Даваасүрэн гишүүн ирсэн, Батжаргал гишүүн ирсэн, Батцэцэг гишүүн ирсэн, чи энийг бүгдийг нь бич, Батцэцэг гишүүн ирсэн байна. Баясгалан гишүүн ЭМЯ-наас гараад одоо орж ирж явна. Булгантуяа гишүүн ирсэн байна, Ганзориг гишүүн ирсэн, Мөнхсоёл гишүүн ирсэн, Мөнхтулга гишүүн ирсэн, Мэндсайхан гишүүн ирсэн, Түвшин гишүүн ирсэн, Тэмүүлэн гишүүн ирсэн, Цогтбаатар гишүүн ирсэн, Чойжилсүрэн гишүүн ирсэн. Ирц 52 хувьтай байгаа учраас хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх 3 асуудал байна. Эхний асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийнэ. 2 дахь асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ. 3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би бас та бүхэнд танилцуулъя эхлээд. Ажлын хэсэг Болдын Жавхлан Сангийн сайд, Д.Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, С.Тэнгис Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны дарга, Р.Мягмаржав Татварын Ерөнхий газар Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга, Ц.Шинэхүү ТӨБЗГ-ын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны

Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, С.Тулга Сангийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Б.Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ө.Саранцэцэг ТӨБЗГ-ын Хууль, эрх зүйн газрын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б.Пунцаг Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны төрийн нарийн, төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглал хариуцсан шинжээч гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Эхлээд би та бүхэнд энэ дагасан хуулиудтай холбогдолтой ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг танилцуулна. Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль, тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, Улсын Их Хуралд суудалтай намын төлөөллийг хангасан 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хамтран ажиллалаа. Ажлын хэсэг хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 19 саналыг гаргаж, гол өөрчлөлтүүдээс дурдъя. Аж ахуйн

нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тухайд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан төслийн жагсаалтыг Улсын Их Хурлаар батлахаар, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал баталдаг байхаар, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн зарим хэсэг заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д заасны дагуу холбогдох бусад зүйлтэй давхацсан байсныг хасахаар, Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсөв, санхүү, татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт тус тус даалгах саналуудыг гаргасан байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, ЗГ-т чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд

ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэхээр заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Биш, биш, алга байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсэгт заасан хугацаанд Төсвийн байнгын хороонд хуулийн төслүүдийн 1 дэх зүйлтэй холбогдуулан ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хоёр.ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Монгол Улсын, энэ буруу явчихлаа шүү. Энэ хүчингүй, саналын томъёолол уншаагүй байхад санал хураалт явуулж болохгүй. Нэг.ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 22.5.22 дахь заалтын үзэл баримтлалд нийцсэн гэснийг үзэл баримтлалд туссан гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн

Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Жаргалан, Б.Заяабал, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд цаашид ажлын хэсэг гэнэ. Энэ 2-ыг нь хамт явъя. Нэгээр нь явах юм уу. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож 13 гишүүн дэмжиж, 71,4 хувиар уг санал дэмжигдсэн байна. Протоколд авчихъя Батжаргал гишүүн дэмжсэн юм байна. Мөнхсоёл гишүүн дэмжсэн юм байна протоколд авъя.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Нөгөө жагсаалтыг Улсын Их Хурал баталдаг болохоор. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. 14 гишүүнээс 13 гишүүн дэмжиж 92,9 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Төсвийн байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Төсвийн

байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Гурав.Гаалийн тариф, гаалийн, энд байхгүй гээд бичсэн байна шүү дээ. Тэгээд энд яагаад тэгээд буруу бичсэн юм бэ? Байсан байна шүү дээ. Энэ дээр нэг буруу юм болсон байна. 1 дүгээр зүйл дээр 3 санал байсан юм байна. Энэ ерөөсөө жоохон буруу юм явсан байна. Энд бичлэгийн алдаа хийсэн байна, дахиад явуулъя. Дахиад явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг 22.5.11, 22.5.20, 22.5.21-д заасан хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, энэ санал 85,7 хувиар дэмжигдсэн байна. Одоо 1 дүгээр болсон уу? Энэ 2-ыг дахиж хураалгах нь байна шүү дээ, 2-ыг тийм ээ.

Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, уг санал 78,6 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор

санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар уг санал дэмжигдсэн байна. Энэ саналыг Батжаргал гишүүн дэмжсэн байна. Протоколд авъя.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Уг асуудлыг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ буруу шүү. Уншаагүй байхад явуулаад байна. Санал уншаагүй байхад битгий явуулаад бай л даа. Энэ хүчингүй.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Батжаргал гишүүн, Мэндсайхан гишүүн 2 дэмжсэн юм байна. 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж 78,6 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Төсвийн байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал. Энэ юу юм бэ, 2 дугаар зүйл юм биш үү? Тэгээд наадах чинь унших юм биш үү, энд байхгүй гээд бичсэн байна шүү дээ. Санал байгаа юм байна шүү дээ. Чи энд санал байхгүй гээд бичсэн, энд санал байгаад байна шүү дээ. 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй саналыг хураалгая.

Төсөлд доор дурдсан агуулгатай “2 дугаар зүйл” нэмэх:

“2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөлөх” гэсний дараа “, хөнгөлөх” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 85,7 хувиар энэхүү санал дэмжигдсэн байна.

3 дахь санал. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 85,7 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя. 3-ыг явуулсан. 4 дүгээр зүйл гээд бас юу болов? Төрийн болон орон нутгийн өмчийнх биз дээ, энэ чинь аль нь юм бэ? Одоо энэ нь явах гээд байна шүү дээ. Тэр нь байхгүй байна шүү дээ.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Төсвийн байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Төсвийн байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Одоо 5 дахь хууль буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье. 3 зүйлтэй. Дээрх хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтийг ирүүлснийг та бүхэнд тараасан. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 11 дэх хэсгийн “, сонгон шалгаруулах этгээдийг” гэснийг “болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр, би уншаад чи тэгвэл тодруул. Этгээдийг өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Өмнөх Төсвийн байнгын хорооны хурал дээр Барилгын тухай хуулийн тэр нөгөө хариуцлагын 3 жилийг жсоохон нэмэгдүүлэх талаар ярьсан. Та болохоор Барилгын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр явагдаж байгаа гэсэн. Энэ түүн дээр хаана байгаа юм бэ? Энэ дээр?

Ц.Даваасүрэн: Энэ дээр бол ороогүй. Барилгын тухай хууль шинээр ер нь өргөн орж ирэх юм. Түүн дээр орж ирэх гэж байгаа байхгүй юу.

Да.Цогтбаатар: Эд нар дээр оруулах боломжгүй байсан юм уу? Би бол эд нар дээр дагалдаж орох гэж байгаа юм чинь.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Нэгэнт хууль ирэх гэж байгаа юм чинь хэрэггүй. Ер нь ингээд 1 хуулийн заалтыг өөр, өөр хуульд оруулаад байхаар жсоохон онцгүй болчихоод байгаа юм. Тийм учраас Барилгын хууль дээр яг энийгээ учир дутагдалтай. Одоо энэ нэг барилгын компаниудын хийгээд байгаа луйврыг

зогсоох, нөгөө иргэдээс мөнгө авчхаад эд нар, тэгээд чиний хэлээд байгаа энэ асуудал энэ тэрийг нэлээн хязгаарласан ийм хуулийн төсөл бэлтгэгдсэн байгаа юм. Тэрүүгээр энэ шийдэгдэх юм.

Дав.Цогтбаатар: За ойлголоо.

Ц.Даваасүрэн: Саяын уншсан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 78,6 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 9 дэх заалтын “болон бусад үйл ажиллагааны” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн орж, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар дэмжигдсэн байна. Би дэмжсэн минийх ажилласангүй аппарат маань.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн “10”, “12” дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 78,6 хувиар энэхүү санал дэмжигдлээ.

Төслийн талаарх, энд чинь өөр юм байгаа юу? Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал Төсвийн байнгын хороонд ирээгүй байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар дэмжигдсэн байна. Мэндсайхан гишүүнийг дэмжсэнд тооцно.

Зургаа. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: ЗГ-ын үнэт цаас гаргахтай холбоотойгоор би бас ажлын хэсэг дээр энэ санал гаргасан юм. Гол онцгой анхаарах асуудал нь ЗГ-аас оруулж ирсэн тогтоол дээр тоо хэмжээг нь заагаагүй. Гадаад үнэт цаас буюу бонд гаргахад зориулалтыг нь бас заагаагүй байгаа. Тэгээд энэ дээр яах вэ ажлын хэсэг дээрээс бид нар би бол яах вэ 2 их наяд төгрөг хүртэлх, 2,5 их наяд төгрөг хүртэлх хүртэлх төгрөгтэй тэнцэх хэмжээний буюу Номад бондын 578 сая ам.доллароор гэдэг хязгаарлалтыг нь хийж өгөөд, зориулалтыг нь зааж өгөөд, дахин санхүүжилт гэдэг асуудлыг бол тавьсан.

Гэтэл яах вэ нэг талдаа ажлын хэсэг дээр олонхоороо санал нь зөвхөн 25 онд 4 их наяд хүртэл төгрөгтэй гэж оруулж ирсэн байгаад байгаа юм. Тэгээд би асуух гээд байгаа зүйл нь 4 их наяд гэдэг тоог хаанаас гаргаж ирж байгаа юм бол? Сангийн сайд энийг үндэслэж оруулж ирж байгаа юм уу? Би бодит үндэслэл нь бол 2,5 их наяд байна гэж хараад байгаа юм. 2,5 их наяд байна гэж ингэж хараад. Яагаад вэ гэхээр Номад бондын тэр дахин санхүүжилт гээд аваад үзэх юм бол 578 сая, 578 сая ам.доллар өөрөө 2 их наяд төгрөгтэй

тэнцэнэ. Дээрээс нь ЗГ-ын дотоод үнэт цаас өөрөө 300 тэрбум, нийслэлийн бонд 190 тэрбум гарсан. Ингээд 2,5 их наяд төгрөг байгаад байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ бид нар аливаа тэр хууль, тогтоолыг баталж байгаа бол үзэл баримтлалтай нийцүүлж хийх ёстой. Зориулалтаас нь давсан их хэмжээний ч гэдэг юм уу 4 их наяд төгрөг хүртэлх гэдэг юм уу ийм хэмжээгүй, хэмжээгүй ч юу байх вэ их хэмжээгээр тоо хэмжээгээ нэмэгдүүлж эрх олгох шаардлага байгаа юм уу, шаардлага байгаа юм уу?

Ц.Даваасүрэн: Тэгэхээр ЗГ-аас өргөсөн саналд тоогүй байгаа байхгүй юу. Тийм учраас гишүүд тоо тавьж өгье гэсэн. Энэ бол зөв. Тэгэхдээ Тэмүүлэн гишүүн бол 2,5 их наяд гээд хэлэлцүүлэг дээр тэр санал дэмжигдээгүй. Хэлэлцүүлгийн явцад ямар асуудал үүссэн гэхээр энэ 2,5-аас гадна дотоод 300 тэрбумын бонд мөн зээлийн дахин санхүүжилтэд бас тодорхой эх үүсвэр авъя. Хэрвээ зах зээл дээр бол ашигтай нөхцөл байдал үүсэх юм бол зарим зээлийн үйлчилгээний төлбөрийг төлье гэдэг агуулгаар бол 4 их наяд хүртэл гэсэн байгаа. Нэмэлт тайлбарыг Сангийн сайд хийчихье. Жавхлан сайдын сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Гишүүдийн санал дээр нэмэлт тайлбар хийе. Тэр ЗГ-аас оруулж ирсэн дагасан тогтоол дээр тоо байхгүй байгаа нь бол зөв. Тэрийг ингээд тоо байхгүй гэхээр бүүр хязгааргүй эрх чөлөө өгөөд, ЗГ хязгааргүй өр нэмээд л ингээд л явах гэж байгаа юм шиг ийм ойлголт зориуд өгч байгаа ч юм шиг ингэмээргүй байгаа юм гишүүдээ. Энэ чинь хууль дээр нь Төсвийн хууль дээр 300 тэрбум төгрөг хүртэл байна гээд заачихсан байгаа. Дотоод болон гадаад бондын зээллэг нийлээд 300 тэрбум. Тэр нь бол яг зээлийн ЗГ-ын өрийн үлдэгдлийг нэмдэг хэсэг цоо шинээр гаргаж байгаа.

Харин *refinance* буюу дахин санхүүжилт хийж байгаа дүнг бол заадаггүй. Тэр нөгөө ЗГ-ын зээллэгийн дүнг өрийн дүнг нэмдэг ч үгүй, хасдаг ч үгүй, харин нөхцөлийг нь сайжруулдаг учраас энэ дээр бол хаана нь ч тэр дүн орж ирдэггүй юм байгаа юм. Тэгээд гишүүд заавал дүн тавина гэсэн учраас 25 онд хуваарь нь тулж байгаа бонд бол байхгүй. 26 онд Номад байгаа, 27 онд Сенчири байгаа. Манай 3 зээлжих зэрэглэлийн 2 нь сайжирчихсан *Moody's*-ийг хүлээж байна. Хэрвээ *Moody's* дээр хэрвээ нааштай дүн гараад сайжрах юм бол бид нар хойтон дараагийн 2 бондуудыг сайжруулах ийм цонх хугацаа үүсэж магадгүй. Тийм учраас нэг нь 570, нөгөөдөх нь 500 байгаа учраас нийлээд 1 тэрбум доллар буюу 3,5 их наядын дахин санхүүжилт хийж болох юм. Нэмэх нь 300 тэрбум буюу ингээд ойролцоогоор энэ чинь 5, 4 их наяд гэж ингэж орж ирж байгаа юм.

Өмнөх тэр яг ЗГ-ын зээлийн өрийн үлдэгдлийг нэмэх нь бол 300 тэрбум гэдэг нь бол урд талдаа орчихсон байгаа хууль дээрээ. Зөрөө нь бол дахин санхүүжилтийнх гэж ойлгох хэрэгтэй. Тэр дахин санхүүжилтээр ЗГ-ын өр нэмэгдэхгүй гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Тэгээд санал хураалт явуулъя. Хэрвээ энэ санал дэмжигдэх юм 4 их наяд хүртэл тоо тавигдана. Дэмжигдэхгүй бол ЗГ-ын хэлснээр тоогүй гэсэн үг. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар дэмжигдсэн байна. Ингээд тоо тавихаар эрхэм гишүүд шийдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? 7 дахь асуудал. Алга

байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх” заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүний, байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Саяын зарчмын зөрүүтэй саналын тэр 3 дахь дээр

төсөвт нь магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх гэсэн ийм томъёолол байгааг байгаа юм. Тэгэхээр төсөвт хугацаа зааж өгмөөр байна л даа. 2025 оны 1 дүгээр улиралд багтаан магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулж, нэгдсэн журмаар шийдвэрлэх гэж хугацаатай болгож өгөхгүй бол наадах чинь явж байгаа ажлын гүйцэтгэл үр дүнд ч их том нөлөө үзүүлэх гээд байна. Нөгөө талдаа гүйцэтгэгч нартаа ч нэлээн том цохилт болчих гээд байна. Тийм учраас энийг цаг хугацаатай болгож ажлыг шуурхай явуулах шаардлагатай. Энэ чинь наадах чинь сая та нэгдсэн юугаар уншсан энэ 1-ийн чинь 3 дахь заалт байхгүй юу. Хөндөгдөөд ороод ирж байгаа заалт шүү дээ ажлын хэсгээс. Болохгүй шүү дээ 2/3 болно шүү дээ тэгэхээр чинь. Энэ дэгт ийм юм орчихсон юм уу?

Ц.Даваасүрэн: Ингэе Батжаргал гишүүнээ. Би чуулганаар хэлэлцэхэд Их Хурлын даргад хэлж байгаад чиглэл авчихъя. Тэгээд гурав дахь хэлэлцүүлэг дээр энийг ярья. Одоо бол болохгүй юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Би дэмжсэн. Миний аппарат бас алдаа гарчихсан учраас энэ саналыг хүчингүй болгоё гэсэн зарчмын горимын санал гаргаж байна. Тийм. Энийг чинь хүчингүй болгох ёстой биз дээ эхлээд. Энэ саналыг хүчингүй болгоё гэсэн миний горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын саналыг 14-өөс 11 гишүүн дэмжсэн учраас горимын санал дэмжигдсэн байна. Өмнөх саналыг дахин дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 10 гишүүн дэмжиж, 71,4-өөр дэмжигдсэн байна. Хэн гишүүн, Баясгалан гишүүн дэмжсэн юм байна протоколд авъя. Энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Эдийн засгийн байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь” дэд заалт нэмэх:

“3/хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оришин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх;” Зөв, зөв. Ингээд дахиад уншъя, будилуулчих юм. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь” дэд заалт нэмэх гэдэг нь Эдийн засгийн байнгын хорооноос гарсан санал байхгүй юу.

“3/хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оришин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 4 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдсэнгүй.

Эдийн засгийн байнгын хорооны 2 дахь санал. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “4 дэх” дэд заалт нэмэх:

“4/инновац шингээж шинээр бүтээгдсэн, олон улсад туршигдсан бараа, материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршилагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14

гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 42,9 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

2.Төсөл доор дурдсан агуулгатай 3 дахь заалт Засгийн газарт чиглэл өгөх төсөл тогтоол дээр нэмэх. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Би эхэлж унших юм байна. Тэрний дараа нь юм байна. 3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөлт эдлүүлэх төслийн жагсаалттай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баярлалаа Даваасүрэн даргаа. Энэ дээр нэг ийм нөгөө хуулийн асуудал үүсэж байгаа юм шүү. Тэгээд гишүүд энийг нэг анхаараад өгөөч. Энэ нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.4 дээр ийм байгаа юм. Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж хамтад нь байршуулна гээд.

Ингээд 11 сарын 15-нд Төсвийн хууль батлагдахаар ингээд нөгөө Ерөнхийлөгчийн хориг энэ тэр гээд хугацаанууд явчихна. Тэгээд Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа дөнгөж өнгөрөөд л 12 сарын 1. Хууль тогтоомжийн хуулийн дагуу энэ төслөө бэлдээд бид ЗГ-ын веб сайт дээрээ хэлэлцүүлэг санал авахаар 60-аас доошгүй хоног байршуулаад дараа нь дахиад хэлэлцүүлэг хийх ийм нарийн ийм зохицуулалттай. Тэгэхээр энэ хугацаа бид нар ингээд биелүүлэх яг ямар ч боломжгүй болоод энэ нь өөрөө хууль зөрчигдөх юм болчихоод байна. Тийм учраас энэ заалт биелүүлэх боломжгүй л нэг ийм заалт болчихоод байна. Тэгээд энийг ямаар юм бэ дээ. Тэгээд бараг энэ чинь намрын чуулганд бараг амжихгүй болж байгаа байхгүй юу яг энэ хуулийнхаа заалтаар нөгөө Хууль тогтоомжийн хуулийн заалтаар. Тэгээд бараг хавар л өргөн барих л ийм л болчихож байгаа юм, Улсын Их Хуралд.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Нэгэнт гаргасан санал учраас хураалгана. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 5 гишүүн дэмжиж, 35,7 хувиар энэ санал унасан байна. 3, 3 уу аль нь вэ, мөн үү?

3.Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “олон нийтэд” гэсний дараа “нээлттэй” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, 42,9 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “төрийн болон орон нутгийн өмчит” гэсний дараа “, төрийн өмчийн оролцоотой” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 57,1 хувиар дэмжигдсэн байна. Ганзориг

гишүүн дэмжсэн юм байна протоколд авлаа.

5.Төслийн 1 дэх заалтын 6 дахь дэд заалтын “төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын” гэснийг “санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар уг санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 78,6 хувиар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож 10 гишүүн 71,4 хувиар энэхүү санал дэмжигдлээ.

Найм.Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Төсвийн байнгын хороонд зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан

ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан нэгдсэн хуралдаанд танилцуулна. Болж байна уу? Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Дараагийнхаа асуудалд оръё. Дагасан хууль дуусчихлаа хэдүүлээ.

19.02 цаг

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Төсвөө хэлэлцэж эхэлье. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье. Монгол Улсын, ажлын хэсэг яг түрүүний эхний хууль дээр байсан яг тэр хэвээрээ байгаа юм байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг. Тэгвэл энэ хооронд Ерөнхий аудитын дүгнэлтийн танилцуулгыг сонсчихъё. Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна аудитын дүгнэлтийг, 5.

Д.Загджав: Та бүхэндээ оройн мэнд өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их

Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, ЗГ-т хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн, нийгмийн тулгамдсан хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864,7 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 35,6 хувь, нийт зарлага 35 тэрбум, 795,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37,7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. Сангийн сайд 5 их наяд 433 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхий аудитор 55,5 тэрбум,

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 312,3 тэрбум, төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төвлөрүүлэх орлогын хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 2 их наяд 813,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь гааль, татварын орлогыг 2 их наяд 986,7 тэрбум төгрөгөөр өсгөж, гадаад тусламжийн орлогыг 141 тэрбум төгрөг буюу, төгрөг бусад орлогыг 32,4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 333,8, 338,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд Сангийн сайдын урсгал зардлын төсвийг 410,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 3 их наяд 184,3, 8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 21,5 тэрбум, гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг 174,8 тэрбум, ЗГ-ын дотоод шилжүүлгийг 240,2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ. Хөрөнгө оруулалтын төсөвт 8 төсөл, арга хэмжээнд нийт 227,2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 4 төсөл, арга хэмжээнд 222,6 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторовн урсгал зардлын төсвийг 10,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 54 аравны, 54 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 8,5 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 1,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсөвт 1 төсөл, арга хэмжээнд нийт 1,5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зарлагын төсвийг 19 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 109,7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь эд хогшил,

урсгал зардлын засварын зардлыг 0,7 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 8,4 тэрбум төгрөг, хувийн хэвилийн байгууллагад олгох татаасыг 9,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь нөлөөлжээ. Хөрөнгө оруулалтын 2025 оны төсөвт 4 төсөл, арга хэмжээнд нийт 202,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 7 төсөл, арга хэмжээнд 33,9 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр тусгасан байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23 дугаар, 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Загджав аудитад баярлалаа. Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуулиудын талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна. Монгол Улсын ЗГ-ын бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформыг хийж, эдийн засгийн суурийг тэлж,

хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлигүй шаардлагатай байна.

Ирэх 2025 он ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд зайлигүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутгийг бие даан хөгжихөд хувийн хэвилийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай юм. Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвилийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсвийн бодлогын 3 онцлогийг дурдъя.

1 дүгээрт анх удаа бүсчилсэн хөгжлийг бүрэн дэмжсэн төсөв боллоо. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 23 жилийн дараа шинэчлэн баталж, газар, түүний баялаг, түүхий эд, нөөцийг оновчтой ашиглан, хүн ам, үйлдвэрлэлийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутгийн тэнцвэргүй байдлыг багасган, хөгжлийн түвшнийг ойртуулж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх эрхэм зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжлийг дэмжих, эдийн засгийн интеграцчилал бий болгоход шаардагдах нэн тэргүүний дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлээ. Өмнө нь бид хөрөнгө оруулалтыг аймаг сумдаар жижиглэж төлөвлөдөг байсан бол ирэх 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг бүс нутгуудыг хөгжүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, бүсүүдэд бизнесийн орчныг сайжруулж, хөрөнгө оруулалт татах, дэд бүтцийн томоохон төслүүдэд чиглүүлэхээр тусгалаа.

Ингэснээр 2028 он гэхэд Монгол Улсын хатуу хучилттай авто зам 4440км-ээр нэмэгдэх бол, эрчим хүчний

салбарт 1650мвт цахилгаан, дулааны эх үүсвэр шинээр бий болж, 1519км цахилгаан дамжуулах агаарын иугамуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Эдгээр хөгжлийн бүтээн байгуулалтуудаас гадна бид нийгмийн салбарын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 93 сургууль, 67 цэцэрлэг, 37 эмнэлэг, 22 дотуур байр болон соёл, спорт чиглэлийн 60, нийгмийн хамгааллын 17 төслийг ашиглалтад оруулна.

2 дугаарт хувийн хэвилийн оролцоог татварын бодлогоор дэмжинэ. Бүсчилсэн хөгжлийг дан ганц хөрөнгө оруулалтаар улсаас шийдэх боломжгүй тул бүс нутгийн эдийн засгийн идэвхжилийг дэмжих, бүсийн татварын ялгаатай бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэ хүрээнд 20 орчим нэр төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломж бүрдэж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, бүс бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлээд байна. Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн зорилтод нийцсэн томоохон бүтээн байгуулалтад хувийн хэвилийн оролцоог урамшуулан идэвхжүүлэх бодлого баримталж, томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг уриалан дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

3 дугаарт нийслэлийн тулгамдсан асуудлыг шийднэ. Нийслэл хотод сүүлийн 30 жилд нийтдээ 11,5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол ирэх 4 жилд нийтдээ 30 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөлөө. Нэн тэргүүнд түгжрэл, агаар, хөрс, усны бохирдол зэрэг нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор 2025 оны төсвийн төсөлд нийслэлд анх удаа 4,5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тусгалаа. Ингэснээр төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх,

авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх юм. Энэ хүрээнд Хөшигийн хөндийн туннел, Өөдөө тэмүүлэх Монгол ган татлагат гүүрэн байгууламжийн мега төслүүдийг ЗГ-ын өрийн баталгаа гаргах замаар ЗГ-ын нэг цэгийн үйлчилгээний цогцолборыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метро төсөл, Туул хурдны зам, шинэ их тойруу хурдны зам, шинэ тойрог авто замын төслүүдийг нийслэлийн эх үүсвэр болон төр, хувийн хэвилийн түншлэлээр тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд агаарын бохирдол 22 орчим хувиар буурч, нийтийн тээврийн хүртээмж нэмэгдэж, түгжрэлийн асуудал шийдэгдэнэ.

Түүнчлэн 37 мянган айлын орон сууц барих дэд бүтцийг бий болгосноор ажлын байр нэмэгдэж, хувийн хэвшил бизнес хийх орчныг бүрдүүлнэ. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан дээрх бодлогыг хэрэгжүүлснээр ирэх онд 83 сая тонн нүүрс, 1,8 сая тонн зэсийн баяжмал экспортлож гадаад худалдааны нийт эргэлтийг 32,8 тэрбум ам.долларт, эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэж, нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 36,8 их наяд төгрөгт хүргэхээр тооцлоо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлэг биз дээ, хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулаад хууль санаачлагч болон

Монгол Улсын Ерөнхий аудитораас асуух асуулттай гишүүд байна уу? Цаана нь санал хураалт их байгаа шүү. Алга байна. Тэмүүлэн гишүүн асуух юм уу? Тэмүүлэн гишүүн, Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Баярмаа гишүүн кноп дарчих.

Г.Тэмүүлэн: Төсвийн байнгын хороон дээр төсвийн төслийг анх удаагаа хэлэлцэж байна. Тийм учраас 2, 3 зүйлийг асуух гэсэн юм. Гол үндсэн асуулт бол ер нь зүгээр яг энэ төсвийнхөө төсөл дээр инфляцаа бодитоор тооцож орж ирж чадаж байгаа юм уу? 6 хувь дээр +, -2 хувь гэж орж ирсэн. Бид бүхэн төсөв өргөн баригдсанаас хойш нөхцөл байдал чинь бас өөрөө их өөр болчихлоо шүү дээ. ЗГ мэдээж улс төрийн шийдэл гаргаж байх шиг байна, эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг оруулж ирж байна. Энэний дам болон дам бус нөлөөллүүд орж ирнэ. Дээрээс нь түүхий эдийн үнийн өсөлт дагасан энэ төсвийн чинь тэлэлт өөрөө бас инфляцад өөрөө нөлөөлнө. Энийг бодитоор нэгд тооцож чадсан юм уу?

2 дугаарт би энэ асуулт бол ОУВС манайд сая 9 сарын сүүлээр төсөв өргөн баригдсаны дараа 9 сарын 20-ноос 10 хоногийн хугацаанд манайд ажилласан гэсэн. 10 сарын 1-нд дүгнэлтээ гаргасан байсан. Олон нийтэд нээлттэй тавьсан. ОУВС бол үзэж байгаа нь угаасаа нэг талдаа манайхны энэ түүхий эдийн үнийн өсөлт дагасан энэ тэлсэн төсөв чинь өөрөө инфляцыг өсгөнө. Гадаад валютын албан нөөцийг бууруулна, ханшийг өсгөнө, урсгал дансны чинь алдагдал буурахгүй байна. Төсвөөсөө нэг талдаа хөрөнгө оруулалтуудыг хийх тусам энэ чинь нөөц болоод хани, инфляц дээр чинь сөргөөр нөлөөлөхөөр байна гэдэг асуудлыг тавиад байгаа юм. Би ОУВС-ийн дүгнэлтээс уншиж байгаа шүү. Тэгээд хэлж байгаа зүйл бол суурь инфляц чинь буугаагүй байгаад байна. 8 сарын байдлаар зорилтот түвшин чинь дээд хязгаартаа хүрчихсэн байна гээд байгаа юм. Тэгээд энэ өргөн барьсан төсөвтэй

чинь холбоотойгоор 24 оны сүүлээс үргэлжлэн өсөж, 26 он хүртэл зорьж байгаагаас чинь өндөр байхаар байна. Суурь шалтгаан бол энэ төсвийн чинь тэлэлт гэж байгаа 1 дүгээрт.

Тэгэхээр энэ бол бүр онцолж хэлж байгаа нь 24 оны чинь төсвийн тодотгол өөрөө энэний нэг зүйл болчихлоо гэж байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр зардлын өсөлтийг хязгаарласан заалтыг авсан энэ асуудлыг хөндөж таарч байх шиг байна. Тэр тусгай шаардлагаа хүртэл та нар буцааж дахиж өөрчил гэдэг энэ асуудлыг бас хөндөж тавьсан байгаад байгаа юм. Буруу байсан гэдгийг.

Хоёрт 25 оны чинь энэ төсвийн тэлэлт болоод эрчим хүчний тарифын өөрчлөлт, зээлийн өндөр өсөлт, түүний нөлөөлөл чинь бас энэ инфляцад чинь нөлөөлнө. Энэ нөхцөл байдал бол та нарын бодож байгаагаас чинь бол 26 он хүртэл өндөр байхаар байна гэсэн дүгнэлтийг бас хэлээд байгаа юм. Би энэтэй бас санал нийлж байгаа зарчмын хувьд. 2-т бид нар төсөв, эдийн засгийн хоёр, эдийн засаг хоёрыг салгаж ойлгож болохгүй. Инфляцын түвшний асуудлыг хэлчихлээ. 2-т ханишийн асуудал. Бид нар нэг талдаа энэ төсвийг хэт тэлэх бодлого чинь өөрөө сөргөөр нөлөөлөх вий дээ, төлбөрийнхөө тэнцэл дээр сөргөөр нөлөөлөх вий дээ, импорт дэмжсэн хэт их хөрөнгө оруулалтууд чинь эргээд энэ ханиш дээр нөлөөлөх асуудлуудыг үүсгэх вий дээ. ОУВС бол төсвийнхөө хэт энэ хэлсэн бодлогоо хумь гэдэг асуудлыг тавьж байгаа юм. Тэр тусгай шаардлагуудаа ханга, өөрчилсөн шаардлагаа дахиж соль. Дээрээс нь төсвийнхөө бодлогыг хатууруул буюу урсгал зардлаа бууруул, уул уурхайн бус орлогоо нэм гэж байгаа юм.

Би энэтэй холбоотойгоор аудитаас асуух гээд байгаа зүйл нь урсгал зардалтай холбоотойгоор та бүхэн ямар дүгнэлт хийсэн юм бэ? Урсгал зардалтай холбоотойгоор.

Үндсэндээ улсын төсвийн чинь зарлага өөрөө 5,3 их наядаар нэмэгдэж байна. Өмнөх оноос 18,7 хувиар нэмэгдэж байна. Тэр дотроо хамгийн их тэлэлттэй байгаа зардал наад урсгал зардлын чинь асуудал байгаа юм. Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, үйлчилгээний чинь зардлын асуудлууд байгаа юм. 1,9 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Магадгүй 3 жилийн өмнө 957 тэрбум төгрөг байсан зүйл одоо 1,9 буюу 2 дахин нэмэгдсэн асуудал байна. Дээрээс нь төрийн энэ байгууллагуудын чинь авлага их нэмэгдсэн байна. Өнөөдөр аудитын дүгнэлт би та бүхнээс харж байгаа шүү, 6,4 их наяд төгрөгийн авлага төрийн байгууллагууд дээр байна гэж байна, энэ ямар үндэслэлтэй юм бэ?

Ц.Даваасүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Эдийн засаг, хөгжлийн яам хариулах байх. Тэрний дараа би нэмж хариулъя. Макро асуултууд учраас.

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам эхлээд хариулъя. Аудит бэлдэж байгаарай Сангийн сайдын дараа. 2 номерын микрофоныг.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Инфляцын төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас өмнө нь бол 6 хувь гээд 25 онд төсөөлж байсан. Гэхдээ одоо салбаруудад хэрэгжүүлэх реформын шинж чанартай асуудлууд, тэгээд төсвийн тэлэлттэй холбоотой бид нар ирэх оны инфляцыг 7,5 хувь гэж тооцоолж байгаа. Мэдээж төсвийн тэлэлт явагдвал инфляц явагддаг нь цаанаа зүй тогтолтой. Гэхдээ төсвийн алдагдлын 2 хувиараа бол төсвийн тэлэлтийг хязгаарлагдаж байгаа учраас бид нар түүн дээр тийм тооцоолол гаргасан байгаа.

Инфляцыг өөрөө цаашаа бид нар үе шаттайгаар 26, 27 онд бууруулахаар зорилт тавьж ажиллаж байгаа. Монголбанкны үндсэн чиг үүргийн нэг бол төгрөгийн тогтвортой байдлыг хадгалах. Энэ бол гадаад, дотоод сектор дээрээ бас тохируулгуудаа хийгээд, инфляцыг бас нам доор түвшинд хадгалах чиглэлээр ажиллана гэж үзэж байгаа. Яг одоогийн байдлаар инфляцын түвшин 6,7 хувьтай байгаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Эдийн засаг, хөгжлийн яамны хариулт дээр нэмж мэдээлэл өгье. Инфляцын түвшин ийм байгаа. Оруулж ирснийг нь сая хэлчихлээ. Одоо 2024 он дуустал Монголбанкны зорилтот түвшин бол 6 дээр +, -2. Сая хэдхэн хоногийн өмнө батлагдсан Монголбанкны Мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр бүр 4 дээр +, -2 гэж байгаа шүү. Өөрөөр хэлбэл тэр лүүгээ чиглэсэн Төв банкны бодлого тийшээ явна гэсэн үг. Мэдээж инфляц хөдлөх, ханиш дээр ирэх дарамтууд энэ эдийн засгийн өсөлтийн үед байж таараа. Харин мөнгөний бодлого нь тэрийгээ онилдог энэ санхүүгийн төв байгууллага нь, эдийн засгийн төв байгууллага нь тэр лүүгээ чиглэсэн бодлогоо явуулахаар бид зөрөөд давхиад энэтэй нийцэхгүй байна. Төсвийн бодлого өөр тийшээ явна гэж болохгүй.

Энэ жил 9 сарын 1-нд төсөв өргөн барьдаг болчихсон. Монголбанк сарын дараа 10 сарын 1-нд Мөнгөний бодлогоо өргөн барьдаг болчихсон. Уг нь зэрэг өргөн барьсан бол зорилтот түвшин нь ижилхэн орж ирэх байх. Ингээд 1 сарын хойно, урд орчихсон учраас энэ ингээд зөрөөтэй ороод ирнэ лээ. Уг нь эргээд бараг Монголбанкныхаа заалтаар 4 дээр +, -2 буюу гэж байгаад бараг 6 болгох ёстой байхгүй юу бага болгоод. Тэгээд эндээ алхмаа тааруулаад, төлбөрийн тэнцэл дээр алхмаа тааруулаад, ер нь бол эдийн засгийнхаа хөрөнгө

оруулалтынхаа энэ орцуудаа тааруулаад явна л гэсэн үг. Мөнгөний бодлого, төсвийн бодлого 2 нийцнэ гэдэг маань энийгээ хэлж байгаа юм.

ОУВС-ийн дүгнэлт бол урьд өмнө байгаагүй эерэг гарсан байгаа. Ялангуяа ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг 7 хувь гэж тооцоолсон байгаа хамгийн сүүлийнхээр. Өмнө нь хэзээ ч ингэж байгаагүй. Сая бас манай Улсын Их Хурлын гишүүд ОУВС, Дэлхийн банкны намрын уулзалтад яваад ирсэн. Би төсөв хэлэлцүүлж байгаа учраас ээлжит жилийнхээ хамгийн гол ажил дээр бас явж амжсангүй. Тэнд ч гэсэн явсан манай гишүүд сонссон байгаа байх. Ер нь яг төсөөлөл дээр бидэнтэй нийцэж байгаа. Тэр дундаа бүр тусгай шаардлагууд дээр хориод жил бид нараас шаардсан ЗГ-ын зээлийн өрийн таазыг 60 хувийг тооцохдоо нэрлэсэн үнээр тооцдог болсон нь энэ тусгай шаардлагыг маш чанаржуулсан ийм зүйл болсон гэдгийг саяын гишүүдээс уншиж байгаа тэр вебсайт дээр нь байгаа. Яг ингэж бичсэн байгаа. Тийм учраас ОУВС, Дэлхийн банкны гаргаж байгаа дүгнэлтүүдтэй төсвийн бодлого хамгийн нийцтэй л ийм төсөв орж ирж байгаа гэсэн үг. 6,4 их наяд гээд тэрийг аудитаас асуусан байх.

Ц.Даваасүрэн: Ерөнхий аудитор, 6 хариулъя, өөрийгөө хэлээд тэгээд танилцуулаад.

Ц.Наранчимэг: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. 2 мянга, Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 3,5 их наядаар нэмж төсөвлөж оруулж ирсэн. Энэ урсгал зардлын төсөвлөлтийг нэмэгдүүлсэн зардлууд бол цалин хөлстэй холбоотой зардал 21 хувийг нь эзэлж байгаа, байр ашиглалттай холбоотой зардал 50 хувь, эд хогшил, урсгал зардал худалдаж авах зардал 69 хувь, томилолттой холбоотой зардал 46 хувь гэх мэтчилэн урсгал зардлыг өсгөж

оруулж ирсэн. Энэ аудитаар аудитын байгууллага Сангийн яам болон төсвийн ерөнхийлөн захирагчдад Улсын Их Хурлаас баталсан Төсвийн хүрээний мэдэгдэл болон хязгаарт үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх дунд хугацааны төсвийн төсөвлөлтийн чанарыг дээшлүүлж, төсвийн сахилга батыг хангаж ажиллах, мөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төрөл ангиллаар нь нарийвчлан тодорхойлж, хуулийн төсөлд тусгаж байх гэсэн ийм зөвлөмжүүдийг хүргүүлсэн байгаа.

Монгол Улсын ЗГ-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6,4 их наяд төгрөгийн авлага байгаа. Үүнээс 449,4 тэрбум төгрөгийн найдваргүй болох авлагын эрсдэл байгаа. ТӨК-уд дээр 2,7 их наяд төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ авлагыг барагдуулах шаардлагатай гэсэн ийм ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулж, Улсын Их Хуралд болон ЗГ-т хүргүүлсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Тэмүүлэн гишүүн нэмэлт 1 минут.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам тэгвэл 7,4-өөр инфляцаа бол тооцсон юм байна гэсэн мэдээллийг сая хэллээ. Тэгээд энэ дотроо тэгвэл сая үндсэндээ сая сүүлийн үед гарч байгаа ЗГ-аас болоод бусад зохицуулах хорооноос гарч байгаа шийдвэрүүдийн нөлөөлөл бол тусгагдаагүй гэсэн үг гэж ойлгох уу? Дам болон дам бус нөлөөллүүд нэгдүгээрх нь.

Дээрээс нь наад урсгал зардлыг чинь нэмэгдүүлж байгаа гол үндсэн факторууд нь яг юу байна вэ? Хамгийн том эзэлж байгаа зардал нь.

Ц.Даваасүрэн: Эхлээд тэр инфляцтай холбогдуулаад байсан уу, өсөлттэй эдийн засгийн өсөлттэй

холбогдуулаад 2 уу? 2 номер. Урсгал зардал 2 дахь нь байсан.

И.Батхүү: Тэмүүлэн гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Эрчим хүчний салбарын реформтой холбоотой ялангуяа тарифын шинэчлэлтэй холбоотой инфляцын нийт нөлөөллийг 2,4 хувь гэж тооцож байгаа. Тэгэхдээ энэ нь бол энэ ондоо бол 2, 1,9 хувь орж ирнэ. Ирэх ондоо дамнаад үлдсэн 0,6 хувь нь, 7, тэгээд тооцоололд нь оруулсан байгаа. 7,5 хувь гэж тооцож байгаа.

Ц.Даваасүрэн: 6 номер, тэр нөгөө урсгал зардлын тэр ашиглалттай холбогдолтой гэдгээр нь бүүр тодорхой хэлчих. Шинэ байшин барилгуудтай холбогдолтой байна шүү дээ.

Ц.Наранчимэг: Урсгал зардлыг 2024 оны төсөвтэй харьцуулж бид нар хувиа бас гаргасан байгаа. Цалин хөлс бол 21 хувийг эзэлж байгаа, байр ашиглалттай холбоотой зардал 863,3 тэрбум төгрөг буюу 50 хувь, эд хогиул, урсгал засварын зардал 267,9 тэрбум буюу 69 хувийг нь, томилолт, зочны зардал 111,7 тэрбум буюу 46 хувийг нь, хангамж бараа, материалын зардал 281,6 тэрбум төгрөг буюу 37 хувиар тус тус нэмэгдсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Энэ дээр нэг зүйлийг бид нар нээрээ анхаарахгүй бол энэ 21 хувь нь л цалин байна шүү дээ. Тэгээд бараг 60, 70 хувь нь бол шинэ байр, барилга ашиглалтад орсонтой холбогдолтой. Дээрээс нь тоног төхөөрөмжүүд байна шүү дээ. Тийм. Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ оройн амрыг эрье. Би тэгээд яах вэ нөгөө зарчмын зөрүүтэй санал оруулсан байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотой асуултаа асууя. Нөгөө хиймэл дагуулын төслийг 25 онд тусгасан тэр зардлыг хасаж өгнө үү гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал оруулсантай холбоотой асуултаа байна. Өнөөдрийг хүртэл би

энийг сайн ойлгохгүй яваад байна. Яг хэдэн долларын эсвэл еврогийн өртөгтэй ийм хиймэл дагуул юм бэ нэг? Хэдэн хувийг нь 2 талын хэлэлцээрээр нэн хөнгөлөлттэй зээлээр авч байгаа юм бэ? Хэдэн хувийг нь, хэдэн банкнаас, ямар хувийн хүүтэй авч байгаа юм бэ, ямар хугацаатай? Нэг ёсондоо 2 арилжааны банкнаас авч байгаа гэж хэлээд байгаа шүү дээ. Ер нь бол сайдуудын ам зөрж байгаа. Нэг сайд нь болохоор 100 хувь нэн хөнгөлөлттэй гэж хэлж байгаа боловч нөгөө сайд нь хэдэн хувь нь ч юм мэдэхгүй 2 арилжааны банкнаас авч байгаа гэж байгаа.

Хоёрт, энэ бол зөвхөн худалдаж авч байгаа үнэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр худалдаж авсны дараа бид тэнд байршуулангуут тэрийг чинь ашиглах тэр хэрэглэгчид нь Монгол Улсад байгаа юм уу? Энэ хэрэглэгчдийнхээ тооцоог гаргасан юм уу? Жишээлбэл өнөөдрийг хүртэл энэ MongolSat, DDish гээд бас бус холбогдох энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд хиймэл дагуулаас суваг сүлжээ авах гээд, түрээсийн гэрээ байгуулчихсан байгаа юм. Тэр түрээсийн гэрээнүүд нь цуцлагдах юм уу? Цуцлаад манай энэ үндэсний хиймэл дагуултай гэрээгээ байгуулах юм уу? Тэгж гэмээ нь тэд нарт зардал гарах уу? Зардал гарах юм бол тэр зардлыг нь хэн, хаанаас хариуцах юм бэ?

Маш их асуулт байна гэхдээ товчилъя. Тэгээд нөгөө малчид хэрэглэгчид маань тэнд хиймэл дагуул хөөрлөө л бол миний та бүгдийн ярианаас шууд энд малынхаа бэлчээр дээр интернэт хэрэглээд унана гэж ингэж ойлгуулаад байгаа, тэгэх юм уу? Тийм боломж байгаа юм уу? Миний судалж мэдсэнээр малчин айлуудын гадаа 100-аас 70см-ийн хэмжээтэй ийм антен төхөөрөмж байршуулах ёстой юм байна лээ. Тэгээд тэрийгээ яг 37км-ийн тэртээд байгаа нөгөө хиймэл дагуул руугаа байршуулж, тохируулах ёстой буюу асар нарийн тохиргоо хэрэгтэй юм гэсэн. Энэний зардал мөнгө хаана

тусгагдсан юм бэ? Мөн энэ малчид хэрэглэхдээ тулбал тэд нарын тэр урсгал зардал буюу урсгал зардал юу байх вэ, тэд нарын төлөх ёстой төлбөрийг нь хэн хариуцах юм бэ? Төрөөс бүгдийг нь ингээд үнэгүй тарааж өгөөд, дээрээс нь хэрэглээний зардлыг нь төлөх гэж байгаа юм уу?

Энэ сансар судлалтай холбоотой гэж үзэх юм бол нөгөө үндэсний чадавх бэхжих юм уу? Энэ чинь бас өмнө нь хөөрхий манай хэдэн энэ төрлийн судлаачид чинь хиймэл дагуул энэ тэр хөөргөөд ажиллаад байгаа. Тэгээд зүгээр нэг худалдаж аваад ашиглачихаар тэр сансар судлалд ямар хувь нэмэртэй юм бэ?

Дээрээс нь 400 мянган тэр антен гэж яриад байгаа юм. Тэгэхээр энийг яг авна малчид авна гэсэн тийм баталгаа байгаа юм уу, тооцоо судалгаа байгаа юм уу? Энэний ар дээр одоогийн байдлаар малчид хэрэглэж байгаа яах вэ малчид юу байх вэ дээ бид бүгд ташираараа хэрэглэж байгаа нөгөө шилэн кабель яах юм бэ? Шилэн кабель хэрэгцээгүй болох юм уу гэсэн ийм асуултууд байна.

Тэгээд тэр их том хүчин чадалтай ийм хиймэл дагуул гэж ойлгож байгаа. Тэгэхээр манай хүн ам маш бага. Тэгэхээр миний ойлгосноор тэр 100 хувийнх нь бараг 10 хувийг нь л хэрэглэх багтаамжтай зах зээл гэж байгаа юм. Тэгэхээр цаана нь 80, 90 хувийг нь яах юм бэ? Бусад улс орон, компани мэдэхгүй, тэд нарт түрээслэх юм уу гэх мэтийн. Тэгээд эргээд бас төрийн байгууллагууд ашигладаг гэж байгаа юм ер нь хиймэл дагуулуудыг. Тэгэхээр нөгөө.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тэгээд хариулсны дараа тодруулж болно. Тэр ашиглалттай нь холбогдолтой нь Жавхлан сайд хариулъя. Тэгээд энэ тэр нөгөө Харилцаа холбооны яамнаас төлөөлөл байна уу ажлын хэсэгт?

Сайдыг нь дуудаарай, яг тэр нөгөө техникийн шинж чанартай асуугаад байгаа зүйлүүдэд нь хариулъя. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Тийм, тийм зээлийн нөхцөл. Зээлийн нөхцөлийн талаар мэдээлэл, Гантогтох, Сонор уу?

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ тэр ашиглалттай нь холбогдолтой хариулж чадах уу?

Б.Жавхлан: Үгүй ээ хэрэггүй.

Ц.Даваасүрэн: Тийм үү? Хариулъя, зээлтэй холбогдолтой.

Б.Жавхлан: Зээлийн нөхцөлүүдтэй холбоотой Гантогтох, хэлтсийн дарга Гантогтох.

Ц.Даваасүрэн: 1 номерын микрофон хариулъя.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Баярмаа гишүүний асуултад хариулъя. Хиймэл дагуулын төслийн санхүүжилтийн хувьд бол одоо хэлэлцээрийн шатад байгаа. Хэлэлцээрийн шатад байгаа дүнгээс дурдах юм бол нийт өртөг нь 225,2 сая евро. Үүнээс Францын ЗГ-ын нэн хөнгөлөлттэй зээлээр 82,7 сая евро буюу зээлийн хүү бол 0.883 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай ийм зээл байгаа.

Дараагийн хэсэг нь болохоор Францын ЗГ-ын төрийн сангийн энгийн нөхцөлтэй зээл болон арилжааны банкнаас авч байгаа ийм зээлийн дүн нийт 106,2 сая евро. Францын сангийн, Францын ЗГ-ын төрийн сангийн хөнгөлөлт энгийн нөхцөлтэй зээл буюу хувьсах хүүтэй ийм зээл байгаа. Тэр нь 25 сая еврогийн үнийн дүнтэй. Арилжааны банкнаас авах зээлийн дүн нь 81 сая еврогийн үнийн дүнтэй. Энэ 2 зээл маань арилжааны нөхцөлтэй ийм зээлийн дүн байгаа.

Ц.Даваасүрэн: Өөр асуултад нь хариулах хүмүүс байна уу? Санал бол байна шүү дээ ажлын хэсэг дээр гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр тусгагдсан үндэсний хиймэл дагуулын төслийн санхүүжилт 211,6 тэрбум төгрөг хасах гээд Баярмаа гишүүний санал хураагдаад унасан. Ингээ ингээд бид нар ажлын хэсэг дээр гарсан дэмжигдсэн саналуудыг хураах үед Харилцаа холбооны сайд Баярмаа гишүүний хариултыг гүйцээж хариулъя. Энэ хооронд дуудъя. Хөдөө аж ахуйн сайд бас байх хэрэгтэй. Ер нь асуултууд гарч магадгүй байгаа учраас сайд нарыг дуудъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Баярмаа гишүүний хариултыг санал хураалт явахад хариулна шүү гүйцээж.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг би та бүхэнд товчхон танилцуулъя. Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны

төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар байгуулан, миний бие ахлан 25 хүний гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Ажлын хэсгүүд 2024 оны 10 дугаар сарын 21, 22, 29-ний өдрүүдэд хуралдсан. Ажлын хэсэг хөрөнгө оруулалт, урсгал зардал болон төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоо холбоотой 3 дэд ажлын хэсэгт хуваагдан ажиллаж, дэд ажлын хэсэг тус бүрийн санал, дүгнэлтийг сонсож, тодорхой зарчмуудыг баримтлан асуудлыг хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэсэн дараах саналуудыг та бүхэнд танилцуулж байна.

Үүнд, 1.Зохицуулалт хийх санал. ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зардлын зардлыг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц дотор зардлын зохицуулалт, зардлын зориулалт өөрчлөх, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал өөрчлөх, төсвийн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгасан 1 дүгээр хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн нэр өөрчлөх зэрэг давхацсан тоогоор Улсын Их Хурлын 28 гишүүдээс төрийн болон төрийн бус 20 байгууллагаас албан бичгээр ирүүлсэн санал бүрийг судалж дээрх зарчимд нийцсэн саналуудыг хуралдаанаар хэлэлцсэн болно. Ажлын хэсгээс шийдвэрлэсэн дээрх асуудлуудтай холбоотой саналын томъёолол тэдгээрийн хавсралтыг та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд
ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Ингээд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх санал.

1.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд урсгал зардал шилжүүлэх санал:

1.1.Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Мал, аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16,492.5 сая төгрөгийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд цаашид “ажлын хэсэг” гэх. Энэ саналыг дэмжсэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, энэ санал 64,3 хувиар дэмжигдсэн байна.

Хоёр.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх санал:

2.1.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.1.29.Баруун босоо тэнхлэгийн авто

замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 70,105.1 сая төгрөг, санхүүжих дүн 20,802.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХХI.1.6.Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга, 80 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 14,587.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,118.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 57,1 хувиар энэ санал дэмжигдсэн байна. Мэндсайхан гишүүн, Батжаргал гишүүд дэмжсэн юм байна, протоколд авъя.

2.2.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮI.1.1.42.Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 22,607.2 сая төгрөг, санхүүжих дүн 13,030.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах, ХҮШ.1.18.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 600.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон ХҮY.1.1.77.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 1,560.0 сая төгрөг, санхүүжих дүн 780.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, нийт 12,880.0 сая төгрөгийн эх үүсвэрээр ХҮШ.1.12.Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, бохир усны гол магистрал шугам 2 дугаар ээлж /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Тахилт, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/, хэрэгжих хугацаа

2025-2026 он, төсөвт өртөг 12,293.2 сая төгрөг, санхүүжих дүн 4,090.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,417.0 сая төгрөгөөр, Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, залууст чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Ховд аймагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зориулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцыг 2,000.0 сая төгрөгөөр, ХIХ.1.9. “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,463.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 85,7 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

2.3.Төслийн 2 дугаар хавсралтын ХIY.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, ХIХ.1.9. “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 92,9 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Гурав.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц хооронд зохицуулалт хийх санал:

3.1.Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд тусгагдсан 49.8 тэрбум төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгон зориулалтыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 8 гишүүн дэмжиж, уг санал 57,1 хувиар дэмжигдсэн байна.

Хоёр.Төсөл, хөтөлбөрийн нэр өөрчлөх санал

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 17.3.5.1.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох гэсэн төсөл, хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар дэмжигдсэн байна. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авъя.

2 дахь санал. Төслийн 2 дугаар хавсралтын ХХ1.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/ гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар дэмжигдсэн байна. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Гурав.Зарчмын зөрүүтэй саналын томъёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал.

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацаа, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, уг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 57,1 хувиар дэмжигдсэн байна. Дэмжсэн юм уу? Батжаргал гишүүн, Цогтбаатар гишүүн, өөр? Ганзориг гишүүн дэмжсэн юм байна.

Дөрөв.Найруулгын санал. 1, найруулгын саналыг та бүхэнд танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь” гэж, 8.1.3 дахь заалтын “хэрэгжилтэд” гэсний дараа “хяналт” гэж, 9.1.1.3 дахь дэд заалтын “дүгнэлт” гэсний дараа “өгөх” гэж, 10.1.2.1 дэх дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Улсын Их Хурлын” гэж, 13.1.10 дахь заалтын “гомдол” гэсний өмнө “зөрчлийн талаарх” гэж тус тус нэмэх.

2.Төсвийн 1 дүгээр хавсралтын 1.1.2 дахь заалтын “бэхжүүлж” гэснийг “хангаж” гэж, 1.2.1 дэх заалтын “Монгол Улсын төр засгийн удирдлага ба төв байгууллагууд” гэснийг “Төрийн байгууллага” гэж, 4.1.1 дэх заалтын “шударга, шуурхай шүүхээр” гэснийг “шударга шүүхээр шуурхай” гэж, 17.1.1

дэх заалтын “аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 25.1.1 дэх заалтын “эд зүйлийн илрүүлэлтийг 50” гэснийг “эд зүйлийн илрүүлэлтийг 85.5” гэж, “хэргийн илрүүлэлтийг 50” гэснийг “хэргийн илрүүлэлтийг 58” гэж, “арга хэмжээг 90” гэснийг “арга хэмжээг 92” гэж, 25.2.1 дэх заалтын “70” гэснийг “72” гэж, “85” гэснийг “86.1” гэж, 25.4.1.4 дэх дэд заалтын “чиглэлээр” гэснийг “ажиллагааны бодит биелэлт” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтын “өргөн”, “гадаад ертөнц”, “дотоодын” гэснийг, 1.2.1.1 дэх дэд заалтын “Дотоодын” гэснийг, 2.1.1.1 дэх дэд заалтын “Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж,” гэснийг, 13.1.1.6 дахь дэд заалтыг, 13.1.6 дахь заалтын “өөрт нь” гэснийг, 17.2.3.2 дахь дэд заалтыг бүхэлд нь, 21.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 85,7 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Тав.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт буюу Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого “279,336.5 сая төгрөг” гэснийг “295,822.0 сая төгрөг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Одоо бусад Байнгын хорооны гишүүд сая ажлын хэсгээс ирүүлсэн саналуудаар санал хурааж дууслаа. Бусад Байнгын хорооны хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын

томъёоллоор санал хураалт явуулж эхэлье. Санал нь энэ байна. Энэ дэмжих ёстой юм уу, дэмжихгүй юм уу энийг. Үгүй юм байна. Зүгээр л ерөөсөө саналыг нь ингээд дэмжинэ гэдгээр оруулж ирээд л дэмжихгүй явчих ёстой юм байна, тэгдэг юм байна шүү. Тухайлсан саналаар юм байна.

Төслийн 2 дугаар хавсралтад Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүхийн байрууд /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 61,600.0 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 10,383.7 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71,983.7 сая төгрөгийн эх үүсвэрийг доор дурдсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулах замаар гаргах: Үүнд:

1.Төслийн 2 дугаар хавсралтын IV.1.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/” төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах;

2.Төслийн 2 дугаар хавсралтын X.2.1.2.Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах /Бүсүүдэд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 11,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

3.Төслийн 2 дугаар хавсралтын X.1.3.2.Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 12,983.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

4.Төслийн 2 дугаар хавсралтын X.3.3.1.Татварын байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 8,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, ХЗБХ дэмжсэн санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ боломжгүй санал шүү,

унахгүй бол болохгүй шүү. Энэ саналууд яачихвал нөгөө техник ТЭЗҮ байхгүй болчих гээд байгаа байхгүй юу. Зураг төсөв хийхийг нь хасчихъя гэхихсэн байгаа байхгүй юу. Болохгүй болчихоод байгаа юм. Тэгээд нөгөө 28 тэрбумаар л нэмэх ёстой байгаа байхгүй юу. Гэтэл энэ чинь 71 тэрбум болчихоод байгаа байхгүй юу. Санал хураалтад 14 гишүүн оролцож 6 гишүүн дэмжиж, 42,9 хувиар энэ санал дэмжигдээгүй байна. Хэлсэн шүү дээ энэ санал дэмжигдсэнгүй.

2 дахь санал. Төслийн 2 дугаар хавсралтын ХХІҮ.1.1.Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,493.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,917.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр ХХІҮ.3.1.Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,942.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар. ХЗБХ дэмжсэн санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад орж, 3 гишүүн дэмжиж, 21,4 хувиар энэ санал дэмжигдээгүй байна. Ер нь дуусах дөхөж байна гишүүд.

3.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд тусгагдсан Нийгмийн халамжийн сангийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилт болох 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс зориулалтаар нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал

байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 7,1 хувиар энэ санал дэмжигдсэнгүй. 92,9 хувиар дэмжигдээгүй гэсэн үг, 7,1 хувиар дэмжигдсэн байна.

4.Төслийн 2 дугаар хавсралтын бүх төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганмаа. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал 14-өөс 3 гишүүнд дэмжиж, дэмжигдсэнгүй. Тийм гишүүнийхээр нь хурааж байгаа байхгүй юу. Тэгээд унаж байна. 5, үгүй ээ үгүй зүгээр Байнгын хороон дээр яасныг нь л хэлж байгаа байхгүй юу.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамигаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамигаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анар. Энэ санал яах вэ Аюулгүй байдлын байнгын хороо дэмжигдсэн юм байна лээ. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж уг санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2 “Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх

хэлэлцээрийг гадаад улсуудтай
үргэлжлүүлэн байгуулах”

Шалгуур үзүүлэлтийн
дугаар: 23.2.2.1

Шалгуур үзүүлэлт: Гадаад
улстай хийх хэлэлцээр

Хэмжих нэгж: Тоо

Суурь он: 2023

Суурь түвшин: 64

2025 оны зорилтот
түвшин: 75” Санал гаргасан Улсын Их
Хурлын гишүүн Анар. Аюулгүй байдлын
байнгын хороо дэмжсэн байна. Дэмжье
гэдэг саналын томъёоллоор санал
хураалт явуулъя. 14-өөс 7, энэ санал
дэмжигдсэнгүй, дэмжигдээгүй гэсэн үг.
Энэ дэмжих ёстой юм биш үү? Тэгээд
бүгд уначихлаа шүү дээ. Энэ Анар
гишүүний гаргасан энэ санал дээр бол
зүгээр та бүгд өөр өөрсдийнхөө байр
суурийг л илэрхийлж болох юм байна
шүү. Зардалд нь нөгөө нэг их өөрчлөлт
орохгүй. Нөгөө төсөв задрахгүй учраас.
Өөрсдөө л мэд. 7, уначихсан ч байсан
болно, унаагүй ч байсан болно гэсэн үг.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын
Гадаад харилцааны сайдын төсвийн
багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн
хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн
хөтөлбөр нэмэх:

“23.5 Үндэсний сөрөн тэсвэрлэх
чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөр 23.5.1

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр
дүн

“Дэлхийн Монголчууд-II” цогц
арга хэмжээг үргэлжлүүлэн
хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар:
23.5.1.1

Шалгуур үзүүлэлт: Арга
хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 95

2025 оны зорилтот түвшин: 100”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн
Анар. Гадаад байдал, аюулгүй байдлын
байнгын хороо дэмжсэн байна. Дэмжье

гэсэн саналын томъёоллоор санал
хураалт явуулъя. 14-өөс 6 гишүүд
дэмжээд энэ санал дэмжигдсэнгүй. Уг нь
дэмжмээр санал байсан байна шүү.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын
Батлан хамгаалах сайдын төсвийн
багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа
хөтөлбөрийн 27.1.1 дэх арга хэмжээг
доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.1.Зэвсэгт хүчнийг
“Нисгэгчгүй нисэх хэрэгсэл”, “Дрон”,
“Хиймэл оюун ухаан”-д суурилсан
дэвшилтэт техник, хэрэгслээр хангах

Шалгуур үзүүлэлтийн
дугаар: 27.1.1.1

Шалгуур үзүүлэлт: Техник
хэрэгслийн хангалт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 8.5

Зорилтот түвшин: 20”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн
Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад
бодлогын байнгын хороо дэмжсэн.
Дэмжье гэсэн саналын томъёоллоор
санал хураалт явуулъя. 14 гишүүн санал
хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж,
64,3 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын
Батлан хамгаалах сайдын төсвийн
багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа
хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.2
гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.1.Энхийг дэмжих
ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх,
зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх

Шалгуур үзүүлэлтийн
дугаар: 27.1.2.1

Шалгуур үзүүлэлт: Бэлэн
байдлын түвшин

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 18

Зорилтот түвшин: 28”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн
Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хорооны дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 4 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдсэнгүй.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.3 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.3.Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.3.1

Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 25

Зорилтот түвшин: 30”

санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анар. Аюулгүй байдал, гадаад байдлын байнгын хороо дэмжсэн байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Яачхав дуу нь? Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж уг санал дэмжигдсэнгүй. Дараагийнх нь аль нь билээ, энэ тийм ээ.

11.Төслийн 1 дүгээр, одоо дуусах дөхөж байна. 11.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.4 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.4.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 10

Зорилтот түвшин: 15”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анар. Гадаад байдал, аюулгүй байдлын байнгын хороо дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, уг санал 71,4 хувиар дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.2

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн

“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.5.2.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 95

2025 оны зорилтот түвшин: 100”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 2 дугаар хавсралтын IX.1.2.“Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баярмаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж, энэ санал

дэмжигдсэнгүй. Батжаргал гишүүнээ, тийм тэрүүгээр нь биш, би дэмжээгүй саналыг дэмжье гэж хураалгахгүй байгаа шүү дээ. Зүгээр танилцуулж байгаа байхгүй юу.

14.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮШ.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

15.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮШ.1.2.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 1 ч гишүүн дэмжсэнгүй. Энэ санал дэмжигдсэнгүй.

16.Орон нутгийн төсвийн хэсэгт 1,100.0 сая төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсанаас Аудитын дүгнэлтэд үндэслэн

Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж байна. Энэ санал дэмжигдсэнгүй.

17.Төслийн 2 дугаар хавсралтын ХХI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 18,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх Үүнд:

1.ХҮ.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

ХҮI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

ХҮI.1.1.15.Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 км /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

ХҮI.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу

хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

ХҮІ.1.2.2.Даланзадгад-

Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

ХҮІ.3.1.1.Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдсэнгүй. Гишүүн нь өөрөө шийдэх байхгүй юу дэгээр. Тэгэхээр сайд эндээ өөрөө л анхаарах хэрэгтэй. Сайддаа хэл. ЗГ-ын гишүүн ийм санал оруулж ирсэн байна.

18.Төслийн 1 дүгээр хавсралтын 17.3.5.1.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион, уншихгүй юм уу, энэ санал хураагдсан санал юм байна шүү.

19.Төслийн 2 дугаар хавсралтын ҮП.4.1.Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 15,645.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BFP-24m” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг болон санхүүжих дүнтэй гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн юм байна. Хэн билээ, Золжаргал гишүүн. Золжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Золжаргал: Энэ нэг ийм инновацийн жижиг бөгөөд хэрэгжихэд бэлэн болчихсон төсөл байгаа 1,2 тэрбум төгрөгийн нийт өртөгтэй. Монгол Улс сүүлийн хэдэн жил энэ нисгэгчгүй нисэх аппарат дроны чиглэлээр хэд хэдэн ийм type загвар хийгээд нисгээд туршичхсан. Хил хамгаалах байгууллагын хүрээнд бас нэлээн олон дроны хил дээр ашиглагдаж байгаа, гадаадад үйлдвэрлэсэн. Тэгээд өөрсдийн юм бэлэн болчихсон. Энийг ерөөсөө тэр 1,2 тэрбумын 2/3 нь тоног төхөөрөмж, 1 нь ажлын хөлс юм байна лээ. Очиж танилцсан. Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр танилцуулга хийгдсэн. Тэгээд эхний хугацаанаасаа хамаараад 5-аас 7 дроныг туршилтынхаа хүрээнд үйлдвэрлээд гаргачихна. Тэрний нэг дроных нь өртөгт нь хуваах юм бол хөрөнгө оруулалтаа бүрэн нөхчихнө. Тэгээд тоног төхөөрөмж нь, мэдлэг нь үлдэх ийм төсөл байгаа шүү. Та бүхэн боломжоороо дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ингээд шинэ төсөл, арга хэмжээ нэмэхгүй гэсэн учраас дэмжигдээгүй юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

20 дахь санал.Төслийн 2 дугаар хавсралтын **ХҮИИ.1.1.Бүсүүдийн** хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Инновац,

цахим бодлогын байнгын хороо дэмжсэн. Уг саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

21.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.3.1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, дэмжигдсэнгүй, 1 ч гишүүн дэмжээгүй байна. Дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.3.1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,590.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,590.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж уг санал дэмжигдсэнгүй.

23.Төслийн 2 дугаар хавсралын IY.2.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 154,491.7 сая төгрөг, санхүүжих дүн 30,444.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл. БСШУ-ы байнгын хороо дэмжсэн юм байна. Уг саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Болох нь байна шүү дээ. 14 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

24.Төслийн 1 дүгээр хавсралтын 28.5.Боловсролын сайд, хөтөлбөр 28.5.1, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ” гэснийг “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн. БСШУ-ы байнгын хороо дэмжээгүй юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж уг санал дэмжигдсэнгүй.

25.Төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг

шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. БСШУ-ы байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүнээс 1 ч гишүүн дэмжигдсэнгүй, дэмжсэнгүй. Уг санал дэмжигдсэнгүй.

26.Төслийн 2 дугаар хавсралтын ХИҮ.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1 их наяд 1,000.5 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 200 ор /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,000.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. БСШУС-ын байнгын хороо дэмжээгүй. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 5 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Рэгдэл гишүүний гаргасан санал хураагдчихсан учраас энэ хураах шаардлагагүй юм байна.

28.Төслийн 2 дугаар хавсралтын ХИҮ.1.1.137.Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 6,710.4 сая төгрөг, санхүүжих дүн 5,910.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,100.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,810.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. БСШУС-

ын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томъёолол санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 1 ч гишүүн дэмжсэнгүй. Уг санал дэмжигдсэнгүй.

29.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. БСШУС-ын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ хооронд Баярмаа гишүүн саналаа тайлбарлая. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Нэг их олон юм бол нэг их яримааргүй байна. Муу хэлэгддэг социализмын үед бид нар мөнгөөр кино үздэг байсан шүү дээ, 1 төгрөгөөр, муу хэлэгддэг социализмын үед. Тэгээд энэ чинь чөлөөт зах зээлийн эдийн засагтай улс болоод 34 жил болж байгаа биз дээ. Тэгээд яахаараа өсвөр насны хүүхдүүдэд ингээд үнэгүй юм үзүүлэх гээд байдаг юм бэ? Тэгээд ямар, би ерөөсөө яагаад ч бүр социализмаас дор болж байна шүү дээ. Социализм чинь үнээр юмаа үздэг байсан шүү дээ мөнгөөр. Тэгээд энэ чинь ерөөсөө сонгодог, би нэг ярилцлага өгөхдөө хэлсэн шүү дээ. Соёл урлаг хэмээх нандин зүйлээр халхавчилсан халамж. Тэгээд нэг соёл урлаг гэдэг нэг гоё ийм маск зүүгээд яг ар дээр нь халамж явж байгаа байхгүй юу.

Энэ чинь ойлгомжтой шүү дээ. 18 нас хүрэх гэж байгаа залуучуудыг үзвэр үзэх тэр мөнгийг нь үнэгүй мөнгө өгснөөр мөнгө шүү дээ энэ чинь ваучер гэдэг чинь, үнэгүй үз гэдэг эрх олгосноор цаана манай яг 18 нас хүрэхэд нь саналыг нь авах гэж байгаа л хэлбэр шүү дээ. Тэгээд яах юм бэ энэ үнэгүй юм үзээд соёлтой болох юм уу, урлагийн мэдрэмжтэй болох юм уу? Соёл урлагийг чинь хүн өөрийнхөө мөнгөөр өөрөө таашааж үздэг биз дээ. Өөрөө театрт очихдоо гоё хувцсаа өмсөөд, мөнгөө төлөөд очиж

үздэг ийм үйлчилгээ шүү дээ. Түүнээс биш төрөөс ингээд шахаад үнэгүй ваучер тараагаад, чи нэг юм үз, тэгээд ар дээр нь 18 нас хүрээд саналаа яаж өгөхөө мэдээрэй гэж байгаа юм шиг л сонсогдож байна. Ний нуугүй хэлэхэд.

Дахиад би хэлье. Адгийн муу хэлдэг социализмын үед үнэгүй юм гэж байгаагүй шүү. Киногоо, жүжгээ бид нар бүгд мөнгө төлөөд үздэг байсан. Тэгээд нэг ийм хүүхдийн нэрийг бариад эсвэл нэг өсвөр үеийнхний нэрийг барьж нэг ийм халамж тараадгаа болих хэрэгтэй шүү дээ. Шинэ 30 жил гээд яриад байгаа биз дээ. Тэгээд энэ чинь яаж ч бодсон социализмаас салаад энэ чинь чөлөөт зах зээлийн эдийн засаг, хувийн хэвшилээ дэмжинэ гэж ярьчаад тэгээд үнэгүй ваучер тараана гээд бүр хуульчлаад өгчихсөн байгаа шүү дээ. Хуульдаа биччихсэн юм байна лээ шүү дээ үнэгүй олгоно гээд. Үнэгүй олгоно гэдэг үг ер нь байж болох юм уу? Үнэгүй олгоно гэдэг юм ер нь дэлхийд байж болох юм уу ер нь яаж ч бодсон. Тэр хуульчилсан үг, нэр томъёогоо хараад бараг ичих хэрэгтэй шүү дээ. Үнэгүй олгоно бүүр яг тэгээд биччихсэн юм байна лээ шүү дээ тэр соёлын бүтээлч юуг дэмжих. Эсхүл энэ кино хийдэг эсвэл жүжиг хийдэг хүмүүсээ дэмжих гээд байгаа юм уу? Энэ зорилго, зорилт нь бол асар тодорхойгүй. Ар дээр нь бол нөгөө сонгуулийн клинглизмын л далд хэлбэр шүү дээ. 18,3 тэрбум төгрөгөөр тэр саяын энэ Завхан аймгийн цэцэрлэгийг барь л даа. Нэг бөөрөнхий цэцэрлэгт 30.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Номин сайд тайлбар хэлье. Номин сайд бүртгүүлсэн юм уу. Тэгээд та 2 сайн мэтгэлц, тэгээд бид нар шийдье.

Ч.Номин: Сайн байцаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Баярмаа гишүүний асуудлыг бол ойлгож байна. Зарим нэг боломжтой чинээлэг айлын хүүхдүүд бол соёлын хүртээмжийг хангалттай авч байгаа. Яг өнөөдрийн байдлаар би нэг хэдхэн

статистик тоо л хэлчихье гэж бодож байна. 2021 оны байдлаар нийт гэмт хэрэгт оролцсон өсвөр насны хүүхдүүдийн тоо 3,7 хувь байсан бол 2022 оны байдлаар 5,4 хувь болж өссөн. 14-өөс 19 насны хүүхдүүд дунд амиа хорлох сэдэлжилт 6 хүүхэд тутмын нэгд байна. Энэ судалгаа олон улсаас хийсэн судалгаа. ЮНИСЕФ-ийн хийсэн судалгаагаар өсвөр насны хүүхдүүд хүний хөгжлийн асуудлаас хамгийн их орхигдож байна. Энэ бол эрүүл мэнд, боловсрол, соёлын асуудлаас хамгийн их орхигдож байна гэдэг зүйл гарч ирсэн. Мэдээж танд хардах эрх байгаа энийг ойлгож байна.

Гэхдээ бидний зарчмын дагаж байгаа чөлөөт зах зээлийг дагаж байгаа тэр Америк, тэр дагаж байгаа Франц, Герман, Испани, Солонгос гээд бүх улсууд чинь ирээдүйн хүүхдүүддээ зориулсан хөрөнгө оруулалтыг бий болгож энэ зүйлийг хийдэг. Энэ бол халамжийн бодлого биш, энэ бол хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын бодлого. Бид нар 100 мянган төгрөгийн эрхийн бичгийг өгснөөр өрсөлдөөн дээр суурилсан олон төрлийн соёл, спортын арга хэмжээнүүдийг бий болгох гэж байгаа. Хүүхдүүд бид нар судалгаа дээр суурилж хийж байгаа. Нийт өнгөрсөн хугацаанд энэ 2023 онд хийсэн судалгаа дээр 54, 59 мянган хүүхэд буюу өсвөр насны хүүхдүүд оролцсон. Яагаад өсвөр насны хүүхдийг онцлоод байгаа вэ гэхээр энэ хичээлээс гадуур хийх аливаа нэгэн зүйл байхгүй байгаагаас болоод хүүхдүүд энэ хэлээд байгаа электрон тамхи гэж хэлээд байгаа архи, тамхинд чинь орж байна. Дахиад кофе шопод л очиж цагаа өнгөрүүлж байна.

Бид нар нэг талдаа өсвөр насныхныг ирээдүйд соёл хүртээж сурсан хүмүүс бий болгохын тулд энэ хөтөлбөрийг гаргаж байгаа. Нөгөө талдаа хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна. Яагаад вэ гэхээр эндээс ашиг олдоггүй учраас энэ зах зээлийн нийгэмд чинь тэр хүүхдүүдэд

чиглэсэн ямарваа нэгэн соёлын болон спортын арга хэмжээ алга. Тийм учраас бид нар энэ хөтөлбөрийг гаргаж байгаа. Тэгэхээр ирээдүйн хүүхэд, залуучууддаа зориулсан хөрөнгө оруулалт. Бид нар энийг сүүлийн 3 жил судалж байгаад хийж байгаа. Ямар ямар нэгэн сонгуультай холбогдолтой зүйл бол биш. Олон улсын хэмжээнд НҮБ-тай хамтарсан 3 жилийн судалгаа дээр суурилж хийгдэж байгаа зүйл бөгөөд нэг талдаа хүний хөгжилд оруулж байгаа хөрөнгө оруулалт, нөгөө талдаа хүүхэд, залуучуудад зориулсан хөтөлбөр, арга хэмжээг нэмэгдүүлэх гэж хийж байгаа. Энэ ваучерыг авсан хүүхдүүд спортоор хичээллэх, ном товхимол худалдаж авах, музей үзэх, номын санд орох буюу чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх арга хэмжээнүүдийг бий болгох гэж байгаа. Ингэснээр нөгөө тэр амиа хорлох сэдэл төрөөд байгаа 6 хүүхэд тутмын 1-ийг багасгах гэж үзэж байна. Нөгөө талдаа дахиад энд тэнд кофе шопод очиж хий дэмий цагаа өнгөрүүлж байгаа хүмүүсийг соёлын орон зайд оруулж илүү гаргах гэж байна.

Ц.Даваасүрэн: Ажиллахаа болчхов уу? 1 удаа тайлбарладаг, болчихсон. Түрүүний санал хураалт техникийн шалтгаанаар явсангүй учраас дахиад санал хураалт явуулъя. Түрүүнийх нөгөө санал хураалт техникийн шалтгаанаар болсонгүй. Дахиад саяын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын Баярмаа. БСШУС-ын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дахиад болохгүй байна. Одоо амжихгүй л дээ, юу ч гэсэн үзье, эвгүйтэж байна даа энэ санал. 14 гишүүнээс 3 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй, үлдчихлээ гэсэн үг. Ажилласан, ажилласан. Энэ чинь юу билээ? Уначихсан гэсэн үг үү? Тэгэхээр яах юм бэ энэ бууруулах гэдэг санал

дэмжигдээгүй тийм биз дээ. Тэгэхээр буурахаар болчхов уу, буурахааргүй болчхов уу? Буурахааргүй болж байгаа юм байна шүү. Би буруу ойлгочихсон байна шүү, буруу ойлгочихож. Тэгэхээр 18 тэрбум 325,9 сая төгрөг үлдээж байна гэсэн үг. Дараагийн санал. Болох юм уу? Дэс дараалал. Протоколд тэмдэглээд явчихвал яадаг юм бэ. Биш ээ, Баярмаагийн санал босоогүй биз дээ? Босоогүй. Түвшин биш ээ, хэн Цогбадрах гишүүн, Цогтбаатар гишүүн.

Дав.Цогтбаатар: Төхөөрөмж сая ажилласангүй энэ санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгнө үү гэдэг горимын санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Цогтбаатар гишүүний горимын саналаар саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн санал хураалт явуулъя. Хүчингүй болгох санал хураалт дэмжигдсэнгүй. Тийм учраас саяын 18,3 сая төгрөг төсөвт үлдлээ.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналуудыг хураалгая. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжсэн санал. 1.Төслийн, хэрэлдэхгүй шүү.

Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.1.36.Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 9,618.3 сая төгрөг, санхүүжих дүн 4,555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2, 3,219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, төсөвт өртөг 14,926.4 сая сая төгрөг, санхүүжих дүн 2,219 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, шинээр нэмж байгаа юм уу? Шинэ төсөл, арга хэмжээг нэмэх гээд байна шүү дээ. Энэ чинь шинээр байна шүү дээ. Үгүй ээ юуг нь заагаагүй байна шүү дээ. Санал гаргасан, энэ зарчим алдагдаж байна даа. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-

өөс 9 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжээгүй санал. Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.178.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2,100.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, ХҮ.1.1.31.Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 11,121.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,548.3 сая төгрөг гэсэн төсөл хэмжээний нэрийн “24 у/м” гэсний дараа “гэрэлтүүлэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх. Дэмжээгүй санал юм байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн оролцож, 7 гишүүн яаж, уг санал дэмжигдсэнгүй. Үгүй ээ зарчмаараа л яв л даа. Ганцаараа чи шинэ юм нэмээд байж болохгүй шүү дээ. Түрүүн нэмэгдчихлээ шүү дээ, одоо болоо шүү дээ. Шинэ юм нэмэгдлээ шүү дээ сая түрүүн. Үгүй ээ болохгүй, өчнөөн олон гишүүн шинэ юм нэмэх гээд ороогүй Батсууриа. Чи ганцаараа нэмж болохгүй. 2 төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.186, 85, хүчингүй болгох гэж байгаа юм уу? Үгүй ээ үгүй хүчингүй болгож байж яана тэгвэл. Хэрвээ яг ийм асуудал дээр бол. Тэгвэл саяын хэд дэх санал байсан билээ энэ чинь? Баясгалан гишүүн горимын санал гаргая гэж байна.

Ж.Баясгалан: Протоколд тэмдэглүүлчихье. Би сая дэмжсэн боловч төхөөрөмж ажилласангүй.

Ц.Даваасүрэн: Микрофондоо хэл, хэлчихсэн юм уу? Хэлчихсэн юм байна.

Ж.Баясгалан: Протоколд тэмдэглүүлчихье, би дэмжсэн, тэгээд төхөөрөмж ажилласангүй.

Ц.Даваасүрэн: Төслийн, тэгэхээр наадхыг чинь санал хураахаас өөр аргагүй болчихоод байна. Тэгвэл ингэчихье. Саяын гаргасан саналыг Баясгалан гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас энэ саналыг хүчингүй болгоё гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдээгүйгээр үлдлээ. 2, 3 уу? Биш ээ, 2 юм байна.

Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.185.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг 2,160.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,300.0 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах /Сүхбаатар/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь. Дэмжээгүй санал байна. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Баярлалаа. Бүгдээрээ ядарч байгаа байх. Тэгээд энэ 17, 18 онд манай Эрдэнэцагаан суманд нэг цэцэрлэг эхлээд тэгээд технологийн алдаа гараад саатчихаад байгаа юм. Тэгээд энэ хөрөнгө тэртээ тэргүй энэ жил тавигдлаа гээд санхүүжихгүй учраас энэ санхүүжилтээс энэ төрийн аудитын хараат бус байдлыг хангах зорилгоор бас нэг байртай болоод явж байгаа юм. Тэгээд манай аймгийн төрийн аудитын байгууллага бол хэзээ нь цагаасаа ерөөсөө байртай байсан түүх байхгүй. Тэгээд олон жил бас гуйсан. Тэгэхээр нэгэнт энэ хэрэглэгдэхгүй байгаа эх үүсвэрийг бас нэг төрийн аудитын байр болгоход сая тэрбум, 1,3 тэрбум төгрөгийг нэмж өгөөч гэж эрхэм гишүүдээсээ хүсэж байна. Бүгдээрээ орой болсон ядарсныг мэдэж

байна. Цөөхөн санал байгаа юм чинь дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналаар. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮП.1.1.24.Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 15,758.5 сая төгрөг, санхүүжих дүн 6,488.0 сая төгрөг төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХҮП.1.1.41.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 3,000.0. сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний “Өгийнуур” гэсний дараа “Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Энэ бас зарчим алдагдсан байна. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Төсөвт өртөг нэмж байна. 10 төрөөс 6 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн нөгөө 2 хоногийн өмнө ирүүлсэн санал. Хэдхэн санал байна гишүүдээ. Тэмүүлэн гишүүний санал байна. Энэ уг нь хураагдчихсан санал байна шүү дээ. Тэмүүлэн гишүүнээ. Нөгөө нэг урсгал зардалд туссан бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээ, үйлчилгээний төлбөр хураамжийг нөгөө 30 хувиар бууруулах гээд энэ хураагдчихсан шүү дээ уг нь. Тэгье. Байна, байна. Бүгдийг нь яана тийм. Тэмүүлэн гишүүн, хураагдсан санал байна шүү энэ нөгөө ажлын хэсэг дээр.

Г.Тэмүүлэн: Би энэ төсвийн тэнцэл сайжруулах үүднээс одоо энэ төсөв дээр тусгагдсан байгаа 1,9 их наяд төгрөгийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 30 хувиар бууруулъя гэсэн саналыг оруулж ирж байгаа. Гэхдээ би энэ дотроо эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарынхныг 30 хувиар бууруулах гэдэг асуудлыг тавьж гарч ирж байгаа. Ингээд аваад үзэхээр үндсэндээ 30 хувиар буурна гэдэг бол 360 тэрбум төгрөгийн асуудал болж гарч ирж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд үндсэндээ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал асар ихээр нэмэгдэж байгаа. 2020 онд 742 тэрбум төгрөг байсан юм. Одоо 1,9 их наяд төгрөг. Тэгээд үндсэндээ би бол өнгөрсөн оных нь, өнгөрсөн оныхоосоо 450 тэрбум төгрөг нэмэгдэж байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн оных нь өсөлтөөс нь ядаж дүйх хэмжээний зардлыг бууруулъя л гэсэн саналыг тавиад байгаа юм. Өнгөрсөн оных нь түвшинд нь буцааж аваачиж тавья гэдэг асуудал байгаад байгаа юм. Нэг талдаа би энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал дээр бас нэг талдаа хардах эрх бас байгаа. Хэмжээгүй гэхээр энэ зардал нэмэгдээд байна. Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудыгаа бүгдийг нь нэр нэрээр нь оруулж ирж тавьж батлуулдаг болооч. Төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр аваачиж гэрээгээр аваачиж гүйцэтгүүлдэг энэ зардлууд чинь арай хэтэрлээ. Энэ бол нийт улсын төсвийн чинь зардлын бараг 6, 7 хувьтай дүйх хэмжээний ийм зардал болж гарч ирж байна гэдэг асуудал тавиад байгаа юм.

Тэгэхээр энэ бол би зүгээр төсвийн тэнцлийг л сайжруулах, төсвийн алдагдлыг бууруулах, ядаж 300 тэрбум төгрөгөөр ч гэсэн бас нэг бууруулах энэ асуудлыг тавья. Нэгдсэн төсвөөс биш, улсын төсвөөс зарлагдаж байгаа, зарлагдаж байгаа бусдаар гүйцэтгүүлэх зардлыг 30 хувиар

бууруулах. Гэхдээ эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт нь гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэгэхээр би гол чухал салбаруудын зардлыг бол бууруулахгүйгээр нийт энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын гэрээгээр гүйцэтгэдэг энэ зардлуудыг 360 тэрбум төгрөгөөр. Аудитын дүгнэлтүүд дээр ч гэсэн бас алдаа, оноотой зүйлүүд бас байгаа. Энийг гаргасан зүйлүүд бас байгаа.

Ц.Даваасүрэн: Энэ санал байна шүү дээ ажлын хэсэг дээр бол дэмжигдээгүй юм. Яагаад гэвэл төсөв нэлээн яах гээд байгаа учраас. Яах вэ Байнгын хорооны гишүүн, тэгэхдээ энэ дээр нэг тийм сонин юм болчихоод байгаа юм. Уг нь нэг дэгээрээ харахаар ажлын хэсэг дээр уначихсан саналуудыг хураалгахгүй байгаа байхгүй юу. Одоо би тэр ажлын хэсэг дээр уначихсан саналуудыг ерөөсөө хураалгаагүй. Гэтэл нэг ийм зөрчил гарч ирчхээд байгаа юм. Төсвийн байнгын хорооны гишүүн тэр хуулийн хугацаанд гаргасан санал байвал хураалгана гэсэн бас юм байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ 2 ингээд хоорондоо зөрчилдөөд байгаа юм. Тийм учраас би танилцууллаа. Уг нь Тэмүүлэн гишүүн татчихвал зүгээр байгаа юм.

Тэгэхдээ хураалгавал би тэгээд л хураалгахаас. Биш ээ биш, зөвхөн Төсвийн байнгын хорооны гишүүнийх тийм болчихоод байгаа байхгүй юу. Байнгын хорооноос өөр, яах вэ ажлын хэсэг дээр унасан санал байна шүү дээ, гишүүн нь өөрөө хүсэлтээ гаргавал Дамдинням, Ганхуяг хоёрынх байгаа. Өөр байхгүй. Ажлын хэсэг дээр ямар санал байсан юм бэ, ямар санал байсан юм бэ ажлын хэсэг дээр? Чинийх байгаа л юм шиг байна шүү дээ. Одоо энэ тийм, байна шүү дээ. Түвшингийн 1 санал байна. Тийм байна, байна. Мөнхтулгын санал байна шүү дээ. Унасан санал ингэж хэлэлцэх нь нэг жоохон тийм болчихоод байгаа байхгүй юу. Биш ээ биш, ажлын хэсэг дээр чинь хураалгасан шүү дээ, уначихсан шүү дээ. Үгүй ээ үгүй ийм байна. Төсвийн

байнгын хороонд ирсэн саналуудыг ажлын хэсэг дээр хураах ёстой юм байна л даа. Тэгээд ажлын хэсэг дээр хураачихгүй юу, тэгээд уначихсан.

Гэтэл нөгөө дэг дээрээ бас ахиад Төсвийн байнгын хорооны гишүүн хуулийн хугацаанд санал гаргасан бол бас хэлэлцэнэ гэгчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд ийм зөрчилтэй л болчихоод байгаа юм. Тэгээд яах вэ жишээлбэл Байнгын хорооны бусад гишүүн нь санал гаргачхаад уначихвал оруулж ирэхгүй. Төсвийн байнгын хорооны гишүүн дахиад хураалгана гэдэг нэг ийм зарчимгүй л юм болчих гээд байна л даа. Тэгээд манай хуулийнхан байна уу? Хуулийнхан нэг юу өгчхөөч.

Ч.Дондогмаа: Чуулганы хуралдааны дэгийн хуулийн 79, 71.9 дээр Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан гээд. 71.6-д нь бол бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын дэд хороодоос ирсэн саналууд байгаа болон Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын байгууллага, нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, энэ хуулийн 71.13-д заасан санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн байгаа юм. Тэгэхээр Төсвийн байнгын хорооны гишүүн гаргасан саналыг хураалгах ийм хуулийн зохицуулалттай байгаа юм. Тийм, дахиж хурааж болно. Тийм ажлын хэсэг дээр унасан, унаагүйгээр хамаарахгүйгээр Төсвийн байнгын хорооны гишүүн гаргасан саналыг хураана гэсэн заалттай.

Ц.Даваасүрэн: Тэгвэл ингээд Тэмүүлэн гишүүний гаргасан ажлын хэсэг дээр унасан Урсгал зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 1,857,913.3 сая төгрөгийг Эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт 30

хувиар бууруулах гэсэн санал Тэмүүлэн гишүүн гаргасан байна. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Би нэг тайлбар хэлье. Энэ OECD нягтлан бодох бүртгэлийн зарчим энэ төсвийн бүртгэлийн зарчим дээр нэг ийм эдийн засгийн ангилал байдаг юм. Англиараа энэ ...of service and goods гэж. Өөрөөр хэлбэл яах вэ Монгол орчуулгыг аягүй олон жил ингээд л явчихсан юм байна лээ. Санаа нь бол тангараг өргөсөн төрийн албан хаагч болон төрийн байгууллага заавал өөрсдөө хийх шаардлагагүй бусдаар хувийн сектороор үйлчилгээ авах зарчмаар хийж болох, хийлгүүлж болох энэ зардлыг л хэлж байгаа юм. Хэдэн жилийн өмнөөс бид нар ийм оролдлогуудыг хийж эхэлсэн. Нэлээн том, том шилжилт гэсэн үг.

Өөрөөр хэлбэл ялангуяа төрийн байгууллагуудын үйлчилгээ, нийтлэг үйлчилгээг хувийн хэвшилээр хийлгүүлэх, үйлчилгээ худалдаж авах замаар төрийн албан хаагчдын тоог энэ асар их тэлж байгаа. Энэ байдал дээр реформ хийх. Ирэх жил жишээ нь ингэж байгаа 50 гаруй тэрбум төгрөг энэ боловсролын салбар дотор байгаа. Шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгүүдийн нийтлэг үйлчилгээ, цэвэрлэгээ үйлчилгээ, хамгаалалт, галлагаа ч гэдэг юм уу эдгээрийг тарифжуулаад хувийн хэвшилээр хийлгүүлээд, төрийн албан хаагчийн шинэ орон тоог нэмэхгүйгээр гэх мэт ийм үйлчилгээнүүдийг худалдаж авах ийм л зүйлүүд байгаа. Дандаа л иймэрхүү зүйлүүд байгаа ихэвчлэн.

Энэ жилийн тоог өсгөж гарч ирж байгаа маань тэр гадаад зээл ашиглалттай холбоотой шүү. Гадаад зээл ашиглалт дотор бас яг ийм ангиллын зардлууд байдаг. Ирэх жил гадаад зээлийн ашиглалт мөн бас 2 дахинаар бид нар нэмчхэж байгаа шүү дээ. Энэ жилийн тодотголоор орсон дүнтэй адилхан. Тэгэхээр өмнөх оныхоосоо нэлээн том ингээд өсөлттэй

байгаа. Тийм учраас эндээс 30 хувь гэдэг бол энэ цаанаа өөрөө .../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Өндөр хувь шүү.

Б.Жавхлан: Төрийн үйл ажиллагааг тасалдуулах, доголдуулах, бүр хорлон сүйтгэж байгаа юм шиг ийм ингэж арай болохгүй, энийг арай болохгүй ингэж. Тийм учраас энийг дэмжмээргүй байна. Энэ цаанаа өөрөө ЗГ-ын үйл ажиллагаа доголдох. Энэ чинь эрүүл мэнд болон тэр боловсрол биш ээ, тэрнээс өөр энэ чинь маш олон салбар байгаа шүү дээ. Нийгэм, халамжийн салбар, энэ эрчим хүчний салбар, энэ дэд бүтцийн салбарууд гээд, батлан хамгаалахын салбар дээр ч энэ байгаа. Тэгэхээр энэ өөрөө энэ ерөөсөө байж болохгүй ийм хасалт шүү.

Өмнө нь ингэж нийтлэг байдлаар хасаж байсан тохиолдол бол ковидын үед бол байгаа, зайлигүй шаардлагатай худалдан авалтуудыг дэмжих зорилгоор. Тэр үед бол бид нар дээд тал нь л 1, 2 хувиар, 3 хувиар хасахад л төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр нэлээн том мэдрэгддэг. Тийм учраас 30 хувь гэдэг бол энэ чинь бүр арай хэтэрхий дүн шүү. Энэ бол арай байж болохгүй.

Ц.Даваасүрэн: Ер нь тийм байх. Тэгээд нэгэнт хэдийгээр ажлын хэсэг дээр унасан ч гэлээ гэсэн Дэгийн тухай хуулиар дахиж хураалгах ёстой гэж манай хуулийнхан үзэж байгаа учраас саяын миний уншсан Тэмүүлэн гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Бүх сайдын багцыг 30 хувиар. Үг саналыг 14 гишүүн санал хураалтад оролцсоноос 3 нь дэмжиж, дэмжигдсэнгүй. Энэ санал дээр бас Баярмаа гишүүн хамтарч гаргаж байгаа гэж ойлгосон. Тийм учраас чуулганы хуралдаанд оруулахдаа хамтарсан байдлаар. Нээрээ тэгээд болохгүй юм байна шүү дээ, болохгүй юм байна нээрээ, тийм байна, тийм байна нээрээ, болохгүй юм байна шүү. Нөгөө Төсвийн байнгын хорооны гишүүний

гаргасан саналыг л хураах ёстой учраас нээрээ болохгүй юм байна.

Одоохон Тэмүүлэн гишүүний 2 дахь санал. Төсвийн Байнгын хорооны гишүүн ингэж давуу эрх эдлэх ч уг нь буруу даа. Энэ бас ноцтой. Яагаад гэвэл бид нар өмнө нь энэ 4 тэрбум, 4 их наяд хүртэл гээд бас хураачихсан санал. Тэгэхдээ энэ санал бас ажлын хэсэг дээр унасан санал байна. Нөгөө ЗГ-ын дотоод, гадаадад гаргах бондын хэмжээ байна шүү дээ тэрийг 3, биш ээ энэ чинь нөгөө юу байна. Энийг нь яг хэлж өгье бид. Нөгөө зээлийн даатгалын юм байсан билүү, тэрийг нь хэлээд өгье. Тэгэхгүй бол та нар бас энийг анхаарахгүй байж магадгүй. Би яг юу байгааг нь тодорхой хэлээд өгчихье.

Төслийн 13 дугаар зүйл буюу Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 25 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг гэснийг 2,500,000.0 сая төгрөг гэж бууруулах. Санал гаргасан Тэмүүлэн. Энэ ажлын хэсэг дээр дэмжигдээгүй санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 3 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Дараах санал. Урсгал зардалд туссан Зээлийн үйлчилгээний төлбөр 1,303,370.7 сая төгрөг гэснийг 1,263,370.7 сая төгрөг гэж өөрчлөх. Санал гаргасан Тэмүүлэн гишүүн. Уг санал ажлын хэсэг дээр дэмжигдээгүй байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 3 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

Түвшин гишүүний гаргасан санал байна уу. Энэ хаанаас хасаад байгаа юм бэ энэ 53-ыг? Шилжүүлээд байгаа юм биш үү. 5 дугаар зүйлийн гэдэг нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 5 дугаар

5.1.5 Эрсдэлийн санг 53,562 сая төгрөгөөр бууруулж, 5 дугаар зүйлийн 5.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. Уг саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 5 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Чойжилсүрэн гишүүний гаргасан санал байна. Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.33. “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/, хэрэгжих хугацаа 2023-2026 он, төсөвт өртөг 135,583.3 сая төгрөг, санхүүжих дүн 34,278.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,900.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Улаан-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам 2.1 км /Увс, Улаангом сум, 5-р баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,400.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,400.0 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн автомашины зогсоол /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чойжилсүрэн. Зарчим зөрчсөн байна шүү. Гишүүний микрофоныг.

Б.Чойжилсүрэн: Энэ төсөвт өртгийг 3,5 тэрбумаар бууруулна гэдэг нь бууруулахгүйгээр зүгээр санхүүжих дүнг нь бууруулъя гэж өгсөн юм, бичсэн юм. Тэгж залруулж уншиж өгөөч.

Ц.Даваасүрэн: Юу гэнэ вэ?

Б.Чойжилсүрэн: Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төсөл /Төв/ гэж заасан төсөл, арга хэмжээнд төсөвт өртгийг 3,5 тэрбумаар бууруул гэж бичихгүйгээр, уншихгүйгээр зүгээр юу санхүүжих дүнг 2,5 тэрбум төгрөг. Төсөвт өртгийг нь хуучин хэвээр нь үлдээнэ гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Үлдээж л байна шүү дээ. Төсөвт өртөг нь 3 тэрбум 500 төгрөг, санхүүжих дүн 2 тэрбум 500 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг нэмэх гэж байгаа байхгүй юу шинээр.

Б.Чойжилсүрэн: Үгүй ээ эхлээд эхнийхээ нөгөө бууруулах санал дээрээ төсөвт өртгийг бууруулахгүйгээр зүгээр санхүүжих дүнг нь 2,5 тэрбумаар бууруулъя.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ санхүүжих дүнг 4 тэрбум 900 сая төгрөгөөр бууруулахгүй бол нөгөө эх үүсвэр гарч ирэхгүй болчихно шүү дээ.

Б.Чойжилсүрэн: Санхүүжих дүнг 2,5 тэрбум байхгүй юу. Та хар даа. Төсөвт өртгийг нь 3,5 гээд.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ үгүй, дээр нь бас ингээд ахиад нөгөө зам дээр чинь 3,4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 2 тэрбум 500 сая төгрөг ахиад шинэ юм ороод ирж байгаа байхгүй юу. Тэгээд ингээд 4 тэрбум 900 чинь ингээд болчихож байгаа юу. Энэ зөв.

Б.Чойжилсүрэн: Үгүй ээ харин тийм. Тэгэхээр 2,5, зөвхөн төсөвт өртөг, санхүүжих дүнг нь буулгаад, төсөвт өртгийг нь хөндөхгүйгээр байсан чинь алдаад биччихжээ, 3,5 тэрбумаар төсөвт өртгийг бууруулах бололцоо байхгүй.

Ц.Даваасүрэн: Төсөвт өртөг бууруулсан юм байхгүй шүү дээ.

Б.Чойжилсүрэн: Байгаа, та эхнийхийг нь унш даа. Уншсан юугаа тэр бууруулах дүнгээ.

Ц.Даваасүрэн: Санхүүжих дүнг 4 тэрбум 900-аар бууруулна гэж байна шүү дээ.

Б.Чойжилсүрэн: Биш ээ санхүүжих дүнг 2,5 тэрбумаар бууруулъя гэж байгаа биз дээ.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ чи өөр юм яриад байна, энэ тийм юм байхгүй байна. Нөгөө Улсын Их Хурлын гишүүн гаргасан бол гэдгээр л юм байна. Уг саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 7 гишүүн яагаад уг санал дэмжигдсэнгүй. Хэнийх, Мэндсайханых юу болсон юм бэ? Одоо өөрчилж болдог юм уу? Өмнө нь ирснээрээ л байх ёстой шүү дээ. Тэрнээс биш одоо өөрчилж болохгүй шүү, хэдүүлээ тэгээд дүрмээрээ л явна шүү.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал”-ыг 9,278.5 сая төгрөгөөр бууруулж, гэж байгаа юм уу, бууруулж, XIX.1.9. “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, 9,278.5 сая төгрөгөөр нэмэх. Санхүүжих дүнг юм уу, юуг нь нэмээд байгаа юм бэ? Санхүүжих дүнг нэмэх. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 4, уг санал дэмжигдсэнгүй.

Түвшин гишүүний санал байна. 3.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮҮ.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 200 ор, /Завхан, Улиастай сум 3 дугаар цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 4,510.1 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Улсын Их Хурлын, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. Зарчимгүй л байна даа энэ чинь.

14-өөс 5 хүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 20,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,850.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн үйлдвэрийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,350.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтулга. Тайлбар хийх юм уу?

П.Мөнхтулга: Энэ яг нөгөө салбарын сайдын багц дотроо шилжиж байгаа юм. Тэгээд агуулга нь юу вэ гэхээр 20 тэрбум төгрөг цахим шилжилт гээд тавьчихсан юм. Тэгээд Хараагүйчүүдийн үндэсний төв гээд нэлээн том байгууллага нэлээн олон гишүүдтэй аймаг, сум болгонд төлөөлөлтэй. Тэгээд энэ байгууллага энэ жилийн төсөв дээр энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хараагүй иргэдийг дэмжсэн юм алга. Манай дээр энэ нэг тоног төхөөрөмж, өөрсдөө нэг үйлдвэрлэл хийх гээд төсөв хараад, тэгээд дэмжих хүмүүс олдохгүй хэцүү байгаад байгаа юм байна лээ. Тэгээд өөрсдөө ингээд хүсэлт тавиад 3,5 тэрбум төгрөг л энэ жилийн төсөв дээр манай дээр нэмээд өгөөч. Тэгэх юм бол бид нар бас нэг үйлдвэрлэл хийчих гээд байна, амьжиргаагаа дээшлүүлчих гээд байна гэж гуйсан юм Холбооноосоо. Тэгээд энийг манай эрхэм гишүүд дэмжиж өгөөч. Нэг их мөнгө биш, нөгөө сайдынхаа багц дотроо л шилжиж байгаа. Тэгээд Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайд. Тэгээд энийг эрхэм гишүүд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ төлөө дэмжиж өгөөч гэж гуйж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Мөнхтулга гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 8 гишүүн дэмжиж, 57,1 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

5.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.7.Дархан-Уул-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, энэний үргэлжлэл нь жсоохон буруу юм биш үү, төгрөг, энэ жсоохон буруу байх шиг байх юм, энэ дахиад мөнгөн дүн болоод явчихлаа шүү дээ. төсөв өртөг, төсөвт нь өртөг нь 630.587 сая төгрөг, санхүүжих дүн нь юм уу, санхүүжих дүн нь 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,200.0 сая төгрөгөөр бууруулж, ХСҮТ-д Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар/, төсөвт өртөг 13,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл /Улаанбаатар/, төсөвт өртөг 5,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,700.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх, шинээр. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 14,700.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Үерийн хамгаалалтын

далангийн засвар шинэчлэлт /Дархан сум 1, 2, 3 дугаар баг/, төсөвт өртөг 7,321.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг, Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам II үе шатны ажил /Дархан-Уул/, төсөвт өртөг 9,723.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/, төсөвт өртөг 17,147.9 сая төгрөг, санхүүжих дүн 5,700.0 сая төгрөг, Өргөх насос станцын тоноглол /Дархан-Уул, Дархан сум/, төсөвт өртөг 8,535.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх, шинээр. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдинням. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-өөс 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Аубакир гишүүний санал хаана байна вэ? Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.70 болон ХҮИ.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66км /Баруун бүс/, 3 тэрбум, энэ юу гэсэн үг юм бэ энэ? 3 тэрбум 957,9 сая төгрөг, 900 энэ чинь ерөөсөө уншигдахгүй байна шүү дээ. 3,957.925418 гэсэн, 18 төгрөг гэсэн хэмжээгээр бууруулж, Хар үзүүр, Ховд голын, Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.19-ийн Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр 217 метр урт зам 0,4км Баян-Өлгий, Алтанцөгц сум. Юуг нь нэмэх юм бэ? Санхүүжих дүнг нь нэмэх юм уу? Санхүүжих дүнг энэ хэмжээгээр буюу 3 тэрбум 957 сая 925 мянга 418 төгрөгөөр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 14-өөс 4 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй.

Ингээд, таны тэр чинь нөгөө 2 хоногийн өмнө гэдгээр хураагдаж болохгүй юм байна. Батсуурь гишүүн горимын санал юм уу? Батсуурь гишүүний микрофоныг.

Ж.Батсуурь: Байнгын хорооны даргаа энэ барилгын салбарынхны нэн тулгамдаж байгаа асуудлын энэ талаар нэг Байнгын хороон дээр санал оруулахгүй бол болохгүй нь. Яагаад вэ гэхээр сүүлийн 7, 8 өдрүүдэд Сангийн яам, манай яам, мөн Байнгын хороонд байнга асуудал тавьж байгаа. Учир юу вэ гэхээр улсын төсвийн хөрөнгөөр барилга, ажил гүйцэтгэж байгаа компаниуд бол үндсэндээ 9 онд нэг ажлынхаа цалингийн тарифыг өөрчилсөн. Дараа нь 19 онд нэг өөрчилсөн. Тэгээд энэ 21 оноос хойш улсын төсөвт орж байгаа ажлууд 19 оны ажлын тарифаар бодогдоод байгаа учраас улс орон даяар байгаа тендерт орсон барилгын компаниуд бүгдээрээ дампуурлын ирмэг дээр хүрэлцэн ирээд байгаа юм.

Тэгээд энэ асуудлыг бол бас шийдэхийн тулд бол тарифын өөрчлөлтийг Сангийн сайд, барилгын, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын хамтарсан тушаал энэ тэр гарсан байдаг. Тэгэхээр энэ асуудлыг нь ер нь нийтэд нь бодоод үзэх юм бол 100 гаруй тэрбум төгрөг байгаа юм. Гэхдээ энэ хүмүүс бол үнэхээр бас дампуурлын ирмэг дээр ирчхээд байна. 21 оноос хойш ажлаа шинэчилсэн тарифаар бол тооцуулах боломж бүрдэнэ гэж бодсоор явж байгаад энэ хүрлээ. Тийм учраас энэ жилдээ багтаагаад 20 тэрбум төгрөг бид нарт нэг асуудлыг шийдэж өгөөч гээд ингээд барилгын 100 гаруй ААН-ийн төлөөлөл Монгол Улсын бүх аймгуудаас ирээд ингээд жагсаал цуглаан хийгээд, санал бодлоо хэлээд байгаа юм. Тийм учраас аль 2019 онд мөрдөгдөж байсан энэ тарифаар явна гэдэг бол одоогийн байдал бол боломж байхгүй байгаа. Хувийн компаниуд 100, 150 мянга, 200 мянган төгрөгийг өдөрт өгч байхад энэ тариф нь өдөрт цагийн 18 мянган төгрөг өгнө л гэсэн. Ийм, биш ээ, өдрийн 18 мянган төгрөг өгнө л гэсэн ийм боломжийг хангаж байгаа учраас

үнэхээр нөхцөл байдал хүнд болчихсон, олон компаниуд дампуурчихсан, олон компани дампуурлын ирмэг дээр ирчихсэн, олон зээл болчихсон ийм нөхцөл бүрдээд байгаа юм.

Тийм учраас энэ онцгой нөхцөлийг бас Их Хурал авч үзэж, эхний ээлжид 20 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг чөлөөлж өгөөч, энэ зохицуулж өгөөч гэж бас хүсэлт гаргаж байна. Санал хурааж өгнө үү?

Ц.Даваасүрэн: Энэ бас бодитой асуудал байгаад байна. Нийтдээ 160 тэрбумын асуудал. Тухайн үед би сайд байхдаа энэ цалингийн зөрөөний асуудлыг шинэчилж баталсан. Тэгээд харамсалтай нь сая төсөв өргөгдөн баригдахад энэ 160 тэрбумын асуудал тусгагдаж орж ирээгүй юм байна лээ. Манай хуулийнхнаас энэ саналыг зарчмын зөрүүтэй саналын томъёолол хурааж болох уу? Гандулам гишүүн, Гандуламын микрофоныг өгье зөвлөхийн, миний хажуу талын микрофон байна.

Б.Гандулам: Ахлах зөвлөх Гандулам. Батсуурь гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцдэг журамтай байгаа. Сая Батсуурь гишүүн бол Төсвийн байнгын хорооны хуралдааны хоёр дугаар хэлэлцүүлэг дээр горимын санал хураалгая гэсэн санал гаргалаа. Дэгийн тухай хуулийн 4.1.3-д бол горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг хэлнэ гэсэн учраас саяын горимын саналаар санал хураалгах боломжгүй.

Ц.Даваасүрэн: Зарчмын зөрүүтэй санал гаргаж болох уу? Хариул, хариул.

Б.Гандулам: Зарчмын зөрүүтэй саналыг бол Төсвийн байнгын хорооны хуралдаанд төсөв хэлэлцүүлэхдээ бол

Төсвийн байнгын хорооны гишүүн 2 өдрийн өмнө буюу Дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд хүргүүлэх ёстой учраас одоо бол нөгөө санал авах хугацаа бол дууссан учраас энэ саналыг бас авах боломжгүй байгаа.

Ц.Даваасүрэн: Шууд зарчмын зөрүүтэй санал гаргаж болохгүй юм байна. Тэгээд та өөрөө нөгөө Төсвийн байнгын хорооны гишүүн ч биш, тэгэхдээ нөгөө Төсвийн байнгын хорооны гишүүн байсан ч гэсэн 2 өдрийн өмнө гаргах ёстой учраас санал хурааж болохгүй болчихоод байна. Тэгэхээр угаасаа энэ асуудал бол хэлэлцэгдсэн байгаа, яригдсан байгаа. 25 оны төсвийг хэрэгжүүлэх тухай дагаж гарах тогтоол дээр энэ төсөвт өртөг нэмэгдсэн болон энэ цалингийн зөрөөг төсөвт тусгах асуудлаар чиглэл өгч байгаа. Харин түүн дээр хугацаатай өгөх талаар гишүүд яриад байгаа юм. Тэрийг 3 дахь хэлэлцүүлэг дээр ярина. Энэ саналаар санал хураах боломжгүй байна.

Одоохон, гишүүд маань орж ирээрэй. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг, бусад Байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүдээс гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дууслаа. Гол ажлынхаа ард гарлаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг миний бие Улсын Их Хуралдаанд танилцуулна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн

тухай хуулийн төслүүдийн хоёр дахь
хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

21.25 цаг

21.23 цаг

**Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн
2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл /Засгийн газар
2024.08.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Байнгын хорооны хуралдаанаар
хэлэлцэгдэх асуудал дууссан тул
өнөөдрийн хуралдааныг хаасныг
мэдэгдье. Байнгын хорооны хуралд
идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

Дараагийнхаа асуудалд оръё.
Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны
төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027
оны төсвийн төсөөллийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн
анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.
Өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн
оролцож байна. Монгол Улсын Их
Хурлын чуулганы хуралдааны дэгийн
тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д
заасны дагуу хуулийн төслийг зүйл
бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2
зүйлтэй. Гишүүн хуулийн төслийн
тухайн зүйлтэй холбогдуулан асуулт
асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй
холбогдуулан асуух асуулттай гишүүн
байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1
дүгээр зүйлтэй холбогдуулан Төсвийн
байнгын хороонд ирүүлсэн зарчмын
зөрүүтэй санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй
холбогдуулан асуух асуулттай гишүүн
байна уу? Төсвийн хүрээний мэдэгдэл.
Асуух асуулттай гишүүн алга байна.
Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй
холбогдуулан Төсвийн байнгын хороонд
ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал
байхгүй байна. Хуулийн төслийн анхны
хэлэлцүүлэг хийсэн талаар Төсвийн
байнгын хорооноос гарсан санал,
дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн
Мэндсайхан нэгдсэн хуралдаанд
танилцуулна. Хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.